

Хойт Америкт зорчихдоо ярьсан Ном

Ли Хонжи

(2002 оны 3 сар)

Сайн байцгаана уу! (*Алга ташив*)

Би та бүгдтэй уулзалгүй удсан байна. Би та нарт хэдэн зүйлийн талаар ярихыг хүсч байна. Намайг ярьж дууссаны дараа та нарт асуух зүйл байвал асууж болно, би энэ боломжийг ашиглан хариулья.

Би гол нь гурван зүйлийн талаар ярина. Нэгдүгээрт: Хүн бүр Ном (Фа) уншихыг тэргүүнд тавих хэрэгтэй. Би үүнийг та нарт байнга хэлдэг. Гэхдээ өнөөдрийн миний ярих бол өөр. Би том учир шалтгааныг нь хэлнэ. Дафа сурагч болгоны хувьд Номоо сайн унших нь тун чухал. Яагаад гэвэл та нарын арга урьдын бясалгалын ямар ч аргаас маш өөр, мөн та нар урьдын бясалгагч нараас аугаа зорилгоороо бас өөр. Энд орчлон ертөнцийн Номыг ярьж байна, хэн Ном сонсохоор ирэх вэ? Ном сонсох хүн юу хийх вэ? Энэ бүгд бол их утга учиртай. Би Дафа сурагчдыг гайхамшигтай гэж хэлсэн. Үнэндээ та нарын хүлээсэн үүрэг хариуцлага бол маш том. Та нар урьд зарим сурагчид надтай гэрээ хийсэн гэдгийг л мэднэ. Үнэндээ бас өөр их олон сурагчид асар холын агуу том өөр орчлон ертөнцүүдээс хувь тавилангийн холбоо тогтоохоор ирсэн. Зарим нь Дафа дэлгэрч үүдээ өргөн нээсэн энэ үед бас орж ирсэн, мөн төрөлхийн суурь сайтай хүмүүс бас орж ирсэн. Манай Дафа-гийн ихэнх сурагчид ийм гурван ангилалд багтдаг.

Боддоо, яагаад алс холын сансарын биетүүдийн амь бодь энд ирсэн бэ? Яагаад гэвэл сансар огторгуйд Номын цэвэрлэгээ болно, тэд бол алс холын сансарын биетүүд, нүсэр уудам орчлон ертөнцүүдийн асар олон бүлгийн амь бодийн төлөөлөгчид, тэд энд Багштай хувь тавилангийн холбоо тогтоохоор ирсэн, Номын цэвэрлэгээгээр бүхэл сансар огторгуй шинэчлэн байгуулагдахад орхигдохгүйн тулд ирсэн, тэдний гол зорилго нь тэндхийн оюун ухаант амь бодийг аврахын тулд юм. Тоо томшгүй олон бүлэг амь бодиуд тэнд байгаа. Надтай гэрээ байгуулсан тэдгээр хүмүүс энгийн гарал үүсэлтэй хүмүүс биш, тэд бас сансарын агуу том биетээс ирсэн. Бодоод үз, хэрэв тэдний түвшин үнэхээр өндөр бол тэд сансарын агуу том биетийг бас төлөөлсөн бус уу? Бас Номын дэлгэрч байгаа энэ үед орж ирсэн зарим сурагчид байдаг, гэхдээ ихэнх нь бас маш өндөр түвшнээс ирсэн.

Миний сая ярьсан бол Ном сонсохоор ирсэн хүмүүсийн талаар юм, хэрэв тийм хүмүүс Ном сонсохоор ирсэн бол бодоод үз, Дафа-гийн сурагч болгон сансарын өөр өөр агуу том биетийг төлөөлсөн биш гэж үү? Хэрэв тийм бол Дафа-гийн сурагчийн сайн муу бясалгаснаас тэдгээр сансарын агуу биетийн амь бодийн аврагдах, аврагдахгүй нь хамаарна гэсэн үг биш үү? Би үүнийг яг тийм асуудал гэж хэлнэ. Учир нь гэвэл, тэр сансарын агуу биет чиний дор, энэ нь бараг чиний бие гэсэн үг, яагаад гэвэл чи тийм л агуу том. Түүн дотор тоо томшгүй олон амь бодь, тоолшгүй олон сансарын орчлон ертөнц оршдог. Чиний бясалгалаас тэдгээр нүсэр том бүлэг амь бодийн сайн муу болох нь, тэдний үлдэх ба үлдэхгүй нь шалтгаална! Микро сансарын түвшинд харвал, хүмүүний орчлонд орших чиний бие бас үнэндээ агуу том систем юм. Чамайг бясалгахад эхлээд чиний биений энэ хэсэг эрүүлжинэ, тэгээд эрүүл хэвээр үлдэнэ, дараа нь аажмаар дээд

энергийн бие бодь болон хувирна. Энэ өөрчлөлт гадна талдаа их биш байж болно. Номын цэвэрлэгээ Сансарын микро ертөнцөөс эхлэн гадаргуйг хүртэл хамарна, бясалгалаар Дафа сурагч бас микрокосмоос гадарга хүртлээ хувьсана. Бясалгалын явцад чиний микро ертөнц дэх биесийн давхарга хурдан дээшилнэ. Мөн бясалгалаар манай ихэнх сурагчдын бие гадаргуйн давхаргад бараг үлдэхгүй болно. Чиний түвшин өндөр бол хариуцлага бас өндөр. Чиний түвшин өндөр байх тусам улам том сансарын биет, улам олон оюун ухаант амь бодийг чи төлөөлнө, чи тэр орчлонгийнхондоо хариуцлага хүлээнэ. Өөрөөр хэлбэл бясалгалын явцад чиний хүний бие дээрдэнэ, улам бүр сайжирна мөн нэгэн зэрэг Бурханы бие болон хувьсана. Сайн бясалгахгүй бол чиний харснаар биеийн гадаргуйн хувьсал бага зэрэг байна. Өөрөөр хэлбэл чиний төлөөлөх агуу сансарын биет бол чиний биетэй адил, энэ нь чиний биетэй хамааралтай. Тиймээс магадгүй олон амь бодь аврагдахгүй, яагаад гэвэл чи сайн бясалгаагүй, тийм учраас тэд сайн болж чадаагүй. Чи тэдэнд саад болох олон зууралдсан сэтгэлийг арилгаагүй нь чамд бас эргээд саад болно.

Би та нарт Ном-оо сайн давт гэж дандаа хэлдэг. Би Фа конференц дээр юмуу өөр үед сурагчидтай уулзах болгондоо Фа уншлагыг тэргүүн зэрэгт тавьж бай гэж үргэлж захидаг, чи ямар ч завгүй байсан Фа унших хэрэгтэй. Тэр үед би дээд түвшний зүйлийг ийм дэлгэрэнгүй хэлэх боломж байгаагүй, үүнийг задалж болохгүй байсан. Гэхдээ чи энэ саад бэрхшээлийг давсны дараа Фа-г илүү гүнзгий ойлгодог болсон, чи бясалгалдаа болон Ном-ыг сурталчлахдаа илүү дадлагажсан. Өнөөдөр би чамд үүнийг хэлж болно: Чиний бясалгал бол огт хувийн хэрэг биш, Гэгээрлийн хутагт зүгээр хүрэх асуудал биш, чиний бясалгал бол чиний хамаарлын, чамд хязгааргүй итгэж найдсан тоо томшгүй олон оюун ухаант амь бодийг аврах асуудал. Та нарын бясалгал бол бүхэлдээ агуу том сансарын орчлон ертөнц бүрийн амь бодийг аврах асуудал юм.

Би яагаад Дафа-гийн сурагчид бол өмнөх үеийн бясалгагчдаас өөр гэж хэлдэг вэ? Би Дафа-гийн сурагчид гайхамшигтай, гэхдээ үнэхээр сайн бясалгавал чиний хүрэх үр дүн үнэхээр гайхамшигтай гэж хэлдэг. Дафа-гийн сурагч бясалгаж үр дүнд хүрэх нь энгийн хүний зөвхөн Гурамсан Ертөнцөөс гарахыг хэлээгүй. Боддоо, та нар сайн бясалгавал агуу сансарт цөөн тооны амь бодь муудна, тэгвэл цөөн хэмжээний амь бодь арчигдана. Буцаад харихад тэд чамайг өөрсдийнхээ жинхэнэ Эзэн, тэдний Хаан гэж үзнэ, чамд хязгааргүй бишрэл хүндэтгэл үзүүлнэ, яагаад гэвэл чи тэднийг аварсан, тэдний төлөө өөрийгээ золиосолсон, чи тэдэнд байгаа юм бүхнийг өгсөн. Харин чи муу бясалгавал олон амь бодь арчигдана, яагаад гэвэл аврагдашгүй болсон амь бодийг байлгаж болохгүй. Яагаад тэр вэ? Энэ хавчилт, хэлмэгдлийн үед өөр орон зайн бүх амь бодь сайн талын амь бодь байж эсвэл муу талын амь бодь болж бүгд үүрэг гүйцэтгэж байна. Муу амь бодь Номын цэвэрлэгээнд саад болж байна, манай сурагчдыг хавчин хэлмэгдүүлж, мөн үүний зэрэгцээ та нарт саад болж байна. Тиймээс тэднийг тун нухацтай устгах хэрэгтэй. Чи сайн бясалгахгүй бол олон амь бодь устана, чи Гэгээрлийн хутгийг олж буцаж харихад чамд урьд нь хязгааргүй итгэл найдвар тавьж байсан маш олон амь бодь устсан болохыг үзнэ. Тэгвэл энэ сансарын агуу орчлон ертөнц, та нарын төлөөлдөг сансарын биетүүд эвдэрч бүтэн биш байдалд орж тоо томшгүй олон амь бодь устгах нь тун болзошгүй.

Та нар олон сурагчид энэ хавчлага хэлмэгдлийн дунд уг учрыг нь сайн ойлгодоггүй, үүнийг хүний эсрэг энгийн хүний хэлмэгдэл гэж үздэгийг мэднэ. Энэ хавчлага, хэлмэгдэл бол бүхэлдээ Дафа-гийн сурагчдын эсрэг хуучин хүчний зохион байгуулсан урьд байгаагүй ад чөтгөрийн сорилт юм. Тэд ашиглаж байгаа муу амь бодид үнэн учрыг мэдүүлдэггүй, тэд жинхэнэ хорлон сүйтгэж байна. Би энэ зохиосон явуулгыг хүлээн зөвшөөрдөггүй ч тэд эцэст нь үүнийг хийж байна. Би тэдний түүхийн туршид зохион явуулсан аль ч зүйлийг хүлээн зөвшөөрдөггүй, Номын

цэвэрлэгээний үед тэднийг бүрэн эсэргүүцэж байна. Тиймээс бид хүн төрөлхтний эсрэг энэ хавчлага, хэлмэгдлийн дунд хүмүүст үнэнийг ойлгуулах хэрэгтэй, үүний зэрэгцээ өөрийгээ сайн бясалгаж ад чөтгөрийг ариун бодлоор устгах хэрэгтэй. Бид хэдийгээр тэдний юуг ч хүлээн зөвшөөрдөггүй боловч энэ хавчлага, хэлмэгдлийн үед тэдний явуулж буй хорлонт гүтгэлэг тоо томшгүй олон амь бодийн ухаан санааг хордуулсан.

Хэрэв одоогийн хүн төрөлхтний ихэнх нь үнэхээр дээд түвшнээс Фа олохоор ирсэн бол бодоод үз, тэгвэл тэд жирийн нэг амь бодь биш. Татагата хүртэл агуу том бүлэг амь бодийг төлөөлдөг. Харин тэд Татагата түвшинд хязгаарлагдахгүй, хүний ертөнцөд ирсэн тэд бүгд агуу чадвартай. Сансарын биетийн маш олон Эзэн, Хаадууд энд ирсэн, тэд асар том сансарын биетийг төлөөлдөг. Гэхдээ энгийн хүний нийгэмд ирснийхээ дараа тэд төөрөлдөж бүр Дафа-г хавчих энэ хэлмэгдүүлэлтэнд хүртэл оролцсон. Хэрэв энэ мэтээр хэн нэгэн устгагдвал бодоод үз, зөвхөн тэр устгагдаж байгаа биш, бас сансарын агуу биет устана.

Би Дафа сурагчид гайхамшигтай гэж хэлсэн. Ийм ширүүн хэлмэгдлийн дунд ч гэсэн та нар дэлхийн хүмүүст үнэнийг ойлгуулж хүмүүсийг аварсаар байна. Боддоо, та нарын аварч байгаа хүмүүс жирийн хүмүүс үү? Хэрэв тэд үнэхээр сансарын агуу биетүүдэд хамааралтай бол чи тэдний аль нэгэнд үнэнийг таниулснаар сансарын агуу биетийг, агуу их бүлэг амь бодийг аварна, чи тэр Эзнийг эсвэл Хааныг аварч байгаа хэрэг. Тэгэхээр Би Дафа сурагчдыг гайхамшигтай гэж хэлж болохгүй гэж үү? Дафа сурагчдын хийж байгаа үйлс бүгд үнэхээр чухал. Урьд хүмүүс амь бодийн авралын тухай ярьдаг байсан, тэдгээр аврагдах амь бодь нь зөвхөн өчүүхэн амь бодь хүмүүн, ердийн хүмүүс байсан. Тэд Дафа сурагчдаар аврагдах шаардлагагүй, Дафа сурагчид хийхэд зохистой биш. Та нарын хийж байгаа зүйлс бүгд маш чухал. Өнөөдрийн хэлмэгдлийн үед хэрэв нэг жирийн энгийн хүн нөгөөдөө "Фалунь Гон-ыг бүү хэлмэгдүүл, Фалунь Гон сайн" гэж хэлсний үр дүнд тэр хүн Фалунь Дафа-гийн сурагчдийг хэлмэгдүүлэхгүй байвал хариуд нь ирээдүйд үлдэж бас бүүр Фа олж авах завшаан олдоно, хэрэв дээд түвшнөөс Фа олохоор бууж ирсэн бол түүний бясалгал хурдан явцтай байна. Тэгвэл боддоо, түүний бүтээлийн оронд хүрсэн нь агуу том бүлэг амь бодь бүтээлийн оронд хүрсэн гэсэн үг, Эзэн эсвэл Хааны бүтээлийн оронд хүрсэн гэсэн үг. Гэхдээ нэг энгийн хүн түүнд бүтээлийн оронд хүрэх боломж өгсөн. Тэр энгийн хүн, нэг жирийн энгийн хүн бүүр агуу Бурхан болно. Тэгвэл Дафа сурагчийн хийж байгаа бол бүр түүнээс ч илүү гайхамшигтай, тэд зөвхөн нэг эсвэл хэд хэдэн хүнийг аварч байгаа биш, тэд дэлхийн хүмүүст үнэнийг таниулах ажлыг байнга идэвхитэй хийсээр бүр олон хүнийг аварч байна, энэ нь гайхамшигтай биш гэж үү?

Би урьд Дафа сурагчид хувь хүний гэгээрлийн хутагт хүрэхэд хэцүү биш гэж хэлсэн. Дафа-гийн сурагчид бясалгалынхаа явцад бүр том хэргийн төлөө өөрсдийнхээ суурийг тавьж байна. Хэрэв хэн нэгэн хувь хүний гэгээрлийн хутагт хүрэхийг хамгийн дээд зорилгоо гэж үзвэл би тэр хүнийг Номын цэвэрлэгээний үеийн Дафа сурагч биш гэж хэлнэ. Тэгвэл хэнийг Номын цэвэрлэгээний үеийн Дафа сурагч гэх вэ? Би бүх дэлхийн хүн ам үндсэндээ 7 тэрбум гэж мэднэ. Урьд манай Дафа-гийн сурагчид бүгд дөнгөж 100 сая орчим байсан. Энэ нь ямар харьцаа вэ? Бусад хүмүүс Фа олж авч чадахгүй гэж үү? Дараагийн үед хүмүүс бас л бясалгана, Гэгээрлийн хутагт хүрэх хүмүүс гарах болно, гэхдээ түүнийг зөвхөн хувь хүний бясалгал гэнэ. Учир нь эхний үед Фа олж авсан сурагчийг " Номын цэвэрлэгээний үеийн Дафа сурагч" гэдэг. Та бүгд Номын цэвэрлэгээний үед оршиж байна, тиймээс Дафа та нарт өндөр хариуцлага зорилго хүлээлгэсэн, харин дараа Фа олж авах хүмүүс бол зөвхөн хувийн бясалгал хийнэ. Тэдэнд ийм хувь тавилан байхгүй, энэ гайхамшигтай үйл хэрэгт оролцох аз завшаан байхгүй. Тиймээс бидний оюун ухаант

амь бодийг аврах нь чухал асуудал, үнэхээр гайхамшигтай хэрэг биш гэж үү? Энэ нь бас тун яаравчлах асуудал.

Би урьд хэлсэн, бид сайн бясалгахгүй бол хожим Гэгээрлийн хутагт хүрэхэд Дафа-гийн сурагчдын хувьд энэ нь зөвхөн хүнд харамсал байгаад зогсохгүй. Сайн бясалгасан сурагчид жинхэнэ дээд Гэгээрлийн хутгийг олоод буцаж харихад тэдэнд туйлын найдвар тавьсан бүх амь бодь аврагдана. Харин сайн бясалгаагүй хэн нэгэн буцаж харихад тэдний ертөнц эвдэрсэн бүтэн биш болсныг үзнэ. Би та нарт хэлэхэд, хэлмэгдлийн үед эсрэг талд орсон, тэрч байтугай маш муу зүйл хийсэн нөхдүүдийг хүртэл Багш нь орхихыг хүсэхгүй байна. *(Алга ташиг)* Тэд өөрсдийнхөө гадаргуйн бүх зүйлийг авч явж чадахгүй болсон. Яагаад гэвэл сайн бясалгаагүй, сайн зүйл хийгээгүй, тэдгээр тоо томшгүй олон амь бодь аврагдахаасаа өнгөрсөн. Би хуучин хүчний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрдөггүй, би энэ хавчлага хэлмэгдлийг хүлээн зөвшөөрдөггүйн хувьд мөн хуучин хүчин Дафа сурагчдын гадаргыг төрөлх мөн чанараас нь тусгаарласан учраас Дафа сурагчид олон зүйлийг хийж чадахгүй болсон, тэдний гадарга давхаргууд ад чөтгөрийн эрхшээлд орж удирдагдан муу зүйл хийсэн, учир нь тэдний сул тал зууралдсан сэтгэлийг ад чөтгөрүүд ашигласан, тиймээс би Дафа сурагчдын төрөлх мөн чанарыг татан гаргана. Дафа сурагчдын гадаргуйг удирдаж муу зүйл хийлгэсэн хуучин хүчин болон хуучин хүчинд ашиглагдан Дафа сурагчдыг гардан хэлмэгдүүлсэн тэдгээр муу амь бодийг бурхны зэргээс нь татан буулгаж бүх чадварыг нь авч хаяна. Тэднийг өөрсдийнх нь хэлмэгдүүлсэн Дафа-гийн сурагчдын нүгэл төрсний дараа олж авсан янз бүрийн үзэл бодлоос бүтсэн хүний биений тэр хэсэгт шахан оруулна. Хүний биеийн тэр хэсэг бодисын солилцооны дүнд устгагдана, тэдэнд ашиглагдсан хүний биеийн хэсэгт тэднийг оруулсны дараа хамтад нь тамд унагана. Яагаад гэвэл хуучин хүчин муу амь бодийг болон хүний нүгэл үзэл бодлыг нь ашиглан муу зүйл хийлгэсэн. Тэгвэл миний тийм сурагчдад ирсэн шигээ буцах боломж олноо гэхдээ тэднийг юу ч хамт авч буцаж чадахгүй болгосон, буцаж очиход нь тэдний төлөөлсөн сансарын агуу биетүүд хоосорсон байна, тэнд урьд нь байсан амь бодиуд байхгүй болсон. Тэд сайн бясалгаагүй учраас бүх зүйлс муу болж арчигдсан, зөвхөн шинээр бүтээхээс өөр аргагүй. Тийм учраас би та нарт хувийн бясалгалдаа Фа уншлагыг тогтмол хийх нь тун чухал гэж хэлдэг. Чи Фа сайн уншихгүй бол Дафа-гийн ажилд олон зүйлийг зөв сайн хийхэд хэцүү болно. Хэрэв Фа сайн давтах юм бол олон зүйлийг хийхэд амархан байхыг үзнэ, үүний зэрэгцээ асуудал бага гарна. Тийм учраас би та нарыг ямарч завгүй байсан заавал Фа уншиж бай гэж хэлдэг.

Сая миний ярьсан бол эхний зүйл. Хоёр дахь зүйл бол бид үнэнийг таниулах ажлыг тэргүүнд тавих хэрэгтэй. Дафа сурагчид үнэнийг таниулахыг маш чухал гэдгийг ойлгох хэрэгтэй. Чи зөвхөн хувийн бясалгал хийж байгаа биш, чиний бясалгал бол өөрийнхөө төлөөлж ирсэн сансарын агуу биет дээрхи амь бодийг аврахад юм. Чамайг үнэнийг таниулж байхад улам олон улам том сансарын биесүүдийг, тэдгээр биесд орших амь бодиудыг нэмж аварч байна, энэ бол Дафа-гийн, түүхийн чамд оноосон үүрэг хариуцлага. Би дээр хэлсэн, хэрэв дэлхийд ер бусын гаралтай маш олон амь бодь ирсэн бол, хэрэв тэд агуу сансарын биетүүдийн Хаадууд, Эзэд, Бурхад бол тэдний төлөөлж байгаа нь агуу сансарын биетүүд, маш олон бүлэг амь бодиуд юм. Тийм хүнийг чи аварвал боддоо, чи Бурханыг аварсан бусуу? Тэр магадгүй маш өндөр түвшний Бурхан, мөн бүр том сансарын биетүүд маш олон амь бодийн төлөөлөгч байж болно. Тэгвэл бид ямар хэмжээний агуу буяны талаар ярьж байна вэ? Энэ нь нэг жирийн зүйл үү? Зөвхөн Дафа-гийн шавь нарт ийм агуу зорилго хүлээлгэдэг.

Иймд та нарт өөрийн бүтээлийн оронд хүрэх бол жижиг зүйл. Та нар түүхэнд олон удаа бясалгасан, ийм замыг олон удаа туулсан. Чиний одоогийн өөрийн бүтээлийн орны шалгуурт хүрэх сорилт бол том асуудал биш. Тэр бол чиний Дафа-г хир ойлгосныг хэмжих шалгуур. Чиний хувийн бясалгалын явц, бүтээлийн оронд хүрэх нь хожим Фа-г хамгаалах, Фа-г батламжлахад тавьсан суурь юм. Яагаад гэвэл чамд тодорхой мөн чанар байх ёстой, чи Фа-г гүн ойлгосон, сайн барьцтай байх ёстой. Мөн үүний зэрэгцээ хувийн бясалгалын явцад өөрийнхээ хүрч чадах шалгуурт бүрэн нийцсэн байх ёстой. Зөвхөн тэр нөхцөлд чи Фа-г жинхэнэ батламжилж чадна, энэ чухал үед Дафа-гийн сурагчийн хийх ёстой зүйлийг хийж чадна. Тиймээс Дафа-гийн сурагчийн хариуцлага бол өөрийн бүтээлийн оронд хүрэхийн тулд биш, харин Фа-г батламжлан хамгаалах явцад оюун ухаант амь бодийг аврах асуудал юм. Энэ бол Дафа сурагчийн түүхэн үүрэг, тийм ч учраас Дафа сурагчид үнэхээр гайхамшигтай.

Би та нарт хэлэхэд, энэ дэлхийн хүмүүс үнэндээ... урьд Бурхад хүнийг анх бүтээх үеийн хүний арьсан дотор байсан эзэн сүнснүүд сүүлийн үед аажмаар өөр орон зайд орхигдох болсон, тэдгээрийг дахин төрөл олохыг зөвшөөрөхгүй болсон. Одоо дийлэнх хүний арьс дээд амь бодид эзлэгдсэн. Өөрөөр хэлбэл, тэд ирж Фа олж авахыг хүссэн, тэдэнд хүний арьс хэрэгтэй. Дафа-гийн сурагчид тэдний дотор багтана. Тийм учраас та нарын үнэнийг таниулах үйлс нь тун чухал.

Мэдээж олон сурагчид үнэнг таниулах их хэмжээний ажлыг даруухнаар хийсээр байгаа, таниулах хуудас тарааж, утсаар ярьж, интернэт хэрэглэж, элчингийн газар очиж, мөн янз бүрийн мэдээллийн хэрэгсэл ашиглан дэлхийн хүмүүст Дафа-гийн талаар үнэнийг хэлж харгис хавчлага, хэлмэгдлийг илчилж байна. Хятадад байгаа сурагчид илүү гайхамшигтай, харгис хүчний хэмжээлшгүй дарамтан доор тэд Фа-г батламжилж оюун ухаант амь бодийг аварч байна. Энэ бүгд ер бусын, энэ бол гайхамшигтай. Нэмж хэлэхэд, энэ бүгдийг та нар өөрийн идэвхээр хийж байна. Өвлийн тэсгэм хүйтэнд ч, зуны халуун наранд ч, эсвэл хаа сайгүй цас мөсөөр хучигдсан үед ч, шаагим бороонд ч, хүмүүс ямар ч зан ааш гаргасан, хичнээн хэцүү байсан ч, та нар бууж өгөөгүй. Багш нь энэ бүгдийг мэдэж байгаа. Би үүнийг харж баяртай байгаа. Би та нарын юу хийх ёстойгоо өөрсдөө сонгосныг мэднэ. Үүнийг Дафа сурагчдын ихэнх нь хийж байна. Мэдээж хичээнгүй бус цөөн хүн байгаа, сайн ойлголтгүй зарим хүмүүс байгаа. Гэхдээ тэд дийлэнх сурагчдыг төлөөлөхгүй. Ихэнх бие бүрэлдэхүүн сайн хийж байгаа. Үүн дээр урагш алхаагүй хүмүүс аажмаар урагш алхаж эхэлж байна. Та нарын хийж байгаа энэ бүгдийг би олон удаа дурьдаж байсан. Дафа сурагчдын хийж байгаа зүйл Фа цэвэрлэгээний шаардлаганд нилээд сайн нийцэж байна. Энэ бүгдэд асуудал алга, маш сайн байна.

Би сая хоёр зүйлийн талаар ярилаа. Гурав дахь зүйл нь бол Ариуслын бодол гаргах. Одоо энэ гурван зүйлийг Дафа-гийн сурагчид хийж байх хэрэгтэй. Ариуслын бодол гаргах бол манай Дафа сурагчдын бас нэг гайхамшигтай зүйл. 1999 оны 7 сарын 22 ноос хойш Дафа, Дафа-гийн сурагчид, дэлхийн хүн төрөлхтөний эсрэг эхэлсэн тэнгэр газрыг хамарсан ийм ширүүн харгис хэлмэгдүүлэлт урьд өмнө болж байгаагүй. Түүхэнд Христийн шашин, Буддын шашин болон бусад шашнуудын хэлмэгдүүлэлт хэзээ ч ийм харгис байгаагүй. Тэр үед ийм хүчирхэг мэдээллийн хэрэгсэл байгаагүй, тээвэр унаа бас хөгжөөгүй байсан, мөн хэлмэгдэл бага хэмжээний газрыг хамарч байсан. Өнөөдөр, Хятадад хамрагдсан газар өргөн, хэлмэгдэлд хохирсон хүний тоо асар их, дан Хятадад тэрбум гаруй хүн шууд хэлмэгдсэн. Гэхдээ энэ хэлмэгдүүлэлт зөвхөн Хятадаар зогсохгүй. Үнэндээ энэ хэлмэгдүүлэлт бол дэлхий дахины, энэ хуурамч гүтгэлэг дэлхийн хүмүүсийн тархийг хордуулсан. Дэлхийг хучсан худал мэдээлэл, ухуулга нь Дафа сурагчдад хэмжээлшгүй хүнд дарамт учруулсан. Маш ноцтой нь ийм худал мэдээлэл, гүтгэлэг нь дэлхий

даяар хүмүүсийн ухааныг хордуулсан. Сансар ертөнцийн Фа бол бүх амь бодийг бүтээсэн. Хэрэв аль нэг хүний толгойд Дафа-гийн эсрэг муу бодол байвал бодоод үз, одоо Фа цэвэрлэгээ явагдаж байна, Фа цэвэрлэгээнд тухайн хүн яаж хандахаас түүний үлдэх, эсвэл устгагдах нь шалтгаална, тэгвэл Фа хүний орчлонг ариусгахад тийм амь бодь үлдэж чадах уу? Хүмүүний орчлонд Фа ариусгал эхлэнгүүт тийм хүн арчигдана. Иймд энэ хэлмэгдэл бүх дэлхийг хамарсан, бүх хүн төрөлхтөнийг хамарсан биш гэж үү?

Дафа сурагчид гайхамшигтай. Хэлмэгдэл анх эхлэхэд та нар хэзээ ч ийм зүйл үзээгүй байсан, та нар сэтгэл санааны хувьд бэлтгэлгүй байсан, та нар юу хийхээ үнэхээр мэдэхгүй байсан. Тэгээд аажмаар та нар биеэ бэлдэж эхэлсэн, аажмаар урагш алхаж Фа-г батламжилж эхэлсэн. Одоо та нар харгислалыг илүү бодлоготой илчилж хүмүүсийг аварч байна. Үндсэндээ бид бүх засгийн газарт, дэлхийн хүн амын ихэнхэд манай Фалунь Дафа сайн гэдгийг ойлгуулсан. Тэд бүгд биднийг хилс хэлмэгдэж байгааг мэднэ, тэд бүгд Хятадын адгийн харгис толгойлогчийн мөн чанар, бурангуй ёсны дураараа авирлах үнэн нүүр царайг мэднэ, тэд улс төрийн хэрцгий бүлэглэлийн харгислалыг тодорхой харж байна. Бид улс төрийн туйлын харгис дарангуйлагчийн ашигласан улс үндэстний суртал нэвтрүүлгийн хүчирхэг машины эсрэг зогсож байна. Бид дэлхийн хүн төрөлхтөнд хэлмэгдлийн үнэнийг мэдүүлж байна, мөн тэдгээр гүтгэлэг, худал суртал ухуулганд тархи нь хордсон хүмүүсийг аварч байна. Энэ бол гайхамшигтай, үнэхээр гайхамшигтай. Эх газрын Хятадын сурагчид ширүүн шахалтанд байгаа ч үүнийг илүү сайн хийж байна. Тэд Хятадын хүн ардыг сэрээж байна. Мөн дэлхий дахины хүмүүсийг бас сэрээж байна, тэд одоо энэ харгис хэлмэгдлийг мэддэг болсон. Хэн ч үүнтэй эвлэрэхгүй, хүн бүр үүнийг эсэргүүцэж байна. Тэгвэл харгис хүчин үүнийг үргэлжлүүлсээр байх уу? Үнэндээ одоо хэлмэгдлийг хөдөлгөгч хүчин зүйлс тун бага үлдсэн, хуучин хүчин Дафа-г сорих хангалттай зүйл алга гэж бодож байна. Ад чөтгөрүүд Дафа-г хэзээ ч үндсээр нь устгаж чадахгүйгээ харсан.

Анх ариуслын бодол гаргаж байснаа санаж байна уу? Тэдгээр Дафа-г хэлмэгдүүлж байсан ад чөтгөрүүд тэр дороо ирж эгнэж зогсоод бөмбөрөө дэлдэж байсан. Та нар хэсэг үеийн турш ариуслын бодол гаргаж байснаар их хэмжээний харгис хүчин зүйлсийг цэвэрлэсэн. Одоо та нар ариуслын бодол гаргахад гарсан гон чинь хаа сайгүй тэдгээр ад чөтгөрүүдийг хайж олох хэрэгтэй болсон. Тэд Дафа сурагчдыг гараа залбиралд авангуут л зугтдаг болсон. Дафа сурагчид харгис хүмүүсийн нүд рүү ариуслын харцаар эгц харахад тэд дальдчидаг. Яагаад гэвэл ариун бодлоос муу хүмүүсийг удирдаж байгаа ад чөтгөрүүд айдаг, тэд тэр дороо түргэн зугтахгүй бол Дафа сурагчдийн ариуслын бодолд устана гэдгээ мэддэг. Тиймээс одоо Хятадад төвлөрсөн харгис хүчин, ад чөтгөрүүдийн бөөгнөрөл байнга агшиж байна. Дэлхийн бусад хэсэгт хүмүүсийн бодлыг удирдаж байсан ад чөтгөрийн хүчин зүйлс устгагдах сүүлийн шатандаа явж байна.

Хэлмэгдэл анх 1999 оны 7 сарын 22 нд эхлэхэд дэлхийн олон хэсэгт хүмүүс Дафа-гийн талаар юу ч мэддэггүй байсныг би санаж байна. "Ийм том хэмжээний дарангуйлал гэнэт юунаас болж Хятадад гарав?" Дэлхий даяар мэдээллийн хэрэгслээр Хятадын худал гүтгэлэг, суртал ухуулга давтагдаж байсан. Тэр үед шахалт дарамт хязгааргүй их байсан. Мэдээж тэр хавчлага бол гадна талын хэлбэр, мөн үндсэн суурь хавчлага бас байсан. Түүхэнд ийм гадны хавчлага хэзээ ч байгаагүй. Та нар энэ хавчлагын эсрэг явж ийм хэмжээнд хүртэл бүхнийг цэвэрлэсэн. Энэ бол үнэхээр гайхамшигтай.

Тэр үед сансар ертөнцийн устгалд харгис хүчин шахагдан дээрээс бууж ирэхэд тэд асар их байсан. Тэд Гурамсан Ертөнц даяар, давхарга давхаргын ширхэгүүдээс тогтсон орон зайнуудад

бүхэлд нь дүүрсэн байсан. Бүхэл сансар ертөнцийн ад чөтгөрүүд дарж байсан, хүн төрөлхтөн, Гурамсан Ертөнц лүү асар том зүйл дарж байсан. Тэр үед хэвлэлд гарсан дэлхийн фото зураг ад чөтгөрийн нүүр шиг байсныг та нар харсан. Тэр бол дэлхийн зөвхөн гадарга давхаргын илрэл байсан. Хэрэв Фа цэвэрлэгээ байгаагүй бол Гурамсан Ертөнц доторхи нэг ч амь бодь үлдэхгүй байх байсан, яагаад гэвэл тэдгээр нь нилээд том хэмжээний сансарын биетийг устгаж чадах хүчирхэг байсан. Фа цэвэрлэгээ эдгээр бүх шахалт үзүүлж байсан зүйлсийг устгасан учраас хүмүүсийн бодлыг хязгаарлаж байсан хүчин зүйлс бүхэлдээ арилсан. Үүний дараа нөхцөл байдалд их өөрчлөлт гарсан. Урьд чамайг үнэнийг ойлгуулах гэхэд их олон хүмүүс сонсохыг огт хүсдэггүй байсан, тэдний зан авир их муу байсан. Тэдгээр зүйлсийг устгасны дараа үнэнийг дахин таниулахад хүмүүс хүлээн авдаг болсон, та нарын хэлснийг сонсдог болсон. Гэхдээ тэдний бодол бас л хангалттай ухаалаг биш байсан, яагаад гэвэл Гурамсан Ертөнцөд орж ирсэн тэдгээр муу амь бодиуд хүмүүсийн сэтгэхүйг удирдсан хэвээр байсан, Дафа-гийн талаар муу ойлголттой хүмүүсийг удирдаж байсан. Худал хуурмаг суртал ухуулгын уршгаар ийм хүмүүс нилээд байсан учраас бидэнд учрах дарамт бас л маш их байсан. Мөн маш олон муу хүмүүс суурь нь болж байсан. Ийм нөхцөл байдалд би та нарыг ариусгалын бодол гаргаж бай гэж хэлсэн. Бидний ариусгалын бодол гаргах явцад хүмүүсийг удирдаж байсан харгис хүчин зүйлс устсаны дараа л дэлхийн хүмүүсийн бодол санаа саруул болж ирсэн.

Фа цэвэрлэгээний бүхий л явцын турш миний *гон* бичил сансар ертөнцөөс гадаргуй луу ойртож ирсээр байна. Тэр явц бол маш хурдан. Фа цэвэрлэгээний хурдын талаар хоромын дараа ярина. Фа цэвэрлэгээний хүч ирэхээс өмнө хүмүүсийн гадаргуйн давхарга, өөрөөр хэлбэл Фа цэвэрлэгээ энэ давхарга луу ойртож байхад, Фа цэвэрлэгээ гадаргуйн давхарга луу орохоос өмнөх энэ завсар хугацаанд харгис хуучин хүчин өөрсдийгээ харуулж байна, хамгийн харгис доод давхаргын, аймшигтай завхарсан этгээд хүмүүсээр Дафа, Дафа-гийн сурагчдыг хэлмэгдүүлж байна. Үүний эсрэг Дафа сурагчид Номыг таниулж Фа цэвэрлэгээ ирэхээс өмнө хүмүүсийг аварч байна. Энэ үед бүх зүйл тод харагдаж байна.

Фа цэвэрлэгээний хүч, үлдсэн бүх орон зайг Фа цэвэрлэгээ бүрэн дуустал дайрч өнгөрнө. Гэхдээ Фа цэвэрлэгээний хүч гадаргуй давхаргад иртэл хуучин Фа, сансарын доройтсон Фа гадаргуй давхаргад оршсон хэвээр байх болно. Тиймээс Фа цэвэрлэгээ иртэл хуучин Фа, хуучин орон зайд байгаа бүх амь бодийг захирсан хэвээр байна. Хэрэв энэ хуучин Фа хэт эрт уствал, Фа цэвэрлэгээ болохоос өмнө уствал бодоод үз, ноцтой асуудал гарна: сансар ертөнц дээрээсээ доош босоо, хэвтээ орон зайнууд бүх орон зай замбараагаа алдана, сансар ертөнцийн бүх цаг хугацаа оршихоо болино, хамгийн том орон зай болж хамгийн хурдан цаг хугацаатай болно, хуучин орон зайнуудад орших бүх амь бодь хамгийн хурднаар, хамгийн хурдан цаг хугацаанд ялзарна, бүх матери бие бодь нэн даруй муудна, Фа цэвэрлэгээнд ороогүй хуучин сансарын гадаргуйд үлдсэн бүх зүйлс хоромхон зуур устаж үгүй болно. Энэ хуучин орчлон ертөнцийн гадаргуйн Фа цэвэрлэгээнд ороогүй багахан хэсэг хүртэл тоо томшгүй олон асар том орон зай, тоологдошгүй олон амь бодь болон Бурхдаас бүрддэг учраас Фа цэвэрлэгээнд орохоос өмнө устгаж болохгүй, тэгвэл Фа цэвэрлэгээ ирэхээс өмнө оюун ухаант амь бодиуд устана, тэд аврагдахгүй болно. Багш зөвхөн та нарыг, дэлхийн хүмүүсийг аварч байгаа биш, бас тэдгээр дээд түвшний амь бодиудыг аварч байгаа. Хуучин амь бодиуд шинэ сансар ертөнц ямар болохыг харж чадахгүй, тэдэнд харахыг ч зөвшөөрөхгүй. Тиймээс тэд хуучин Фа зарчмыг дагадаг, хуучин сансар ертөнцийн бүх зүйлийг баримталдаг. Тийм учраас тэд миний тавьсан шинэ сансар ертөнцийн шаардлагыг дагахыг хүсдэггүй, үүнийг харж чаддаггүй. Фа цэвэрлэгээний үед хуучин Фа үнэн хэрэгтээ надад болон Дафа-гийн сурагчдад саад болон нөлөөлж байна. Надад үүнийг устгах чадвар бий. Гэхдээ

бүх амь бодийг аврахын тулд устгаж болохгүй гэж би сая хэлсэн. Хэрэв устгавал тэдгээр амь бодиуд аврагдахгүй, тэдгээр сансарын биетүүд дээрхи бүх амь бодиуд бүрмөсөн дуусна. Үүнээс гадна, манай Дафа сурагчдын үндсэн бие энд байгаа учраас аврахад улам хэцүү болно.

Тэгэхээр олон зүйлийн зөвхөн амрыг нь харж болохгүй. Хэрэв энэ хуучин Фа-г дуусгахгүй бол Фа цэвэрлэгээг хүндрүүлнэ, хэрэв дуусгачихвал амь бодийг аврахад ноцтой уршиг тарина. Дафа сурагчид ариусгалын бодол, цэвэр ариун бодол гаргаж харгис хэлмэгдлийг дарахыг зөвшөөрдөг, хуучин Фа зарчимд бас ийм зүйл байдаг. Энэ нь ариун бодлоор бясалгахтай болон ариун бодлоор амь бодийг аврахтай адил санаа. Тийм учраас та нар үүнийг хийж болно. Хэрэв багш та нарын өмнөөс үүнийг хийвэл хуучин Фа зарчим, хуучин Бурхдууд хүлээн зөвшөөрөхгүй. Би та нарт аль хэдийн олон зүйлийг хийж өгсөн, хэрэв хэтэрхий их хийж өгвөл эсвэл бүхнийг гардан хийгээд байвал хуучин Фа зарчим, хуучин сансарын амь бодь үүнийг хараад огт тэвчихгүй. Намайг та нарын бүх зүйлийг хийж өгөөд байвал Дафа сурагчид бясалгалаа өөрсдөө хийхгүй байна гэж тэд үзнэ. Тиймээс тэд эсэргүүцэн босно.

Мэдээж, хэрэв надад саад болбол би тэднийг устгаж чадна. Гэхдээ тэгж болох уу? Олон зүйлс тийм амар биш. Би та нарт нэг жишээ хэлье. Хятадад зарим сурагчид өөрийгээ сайн удирдаж чадаагүй. Тэд хэлмэгдэн баривчлагдахад тэдгээр зэрлэг цагдаа нар маш хэрцгий зоддог. Тэр үед зарим сурагчид хангалттай зөв бодолтой байдаггүйгээс тэдний хэлмэгдлийн зовлон улам хүндэрдэг. Тэд харгисаар зодуулж байхдаа өөрсдийгээ Дафа сурагч гэдгээ мартчихдаг, тэд Багшаасаа тусламж гуйя гэж боддоггүй. Эсвэл зарим хүн Багшаасаа тусламж гуйсан ч тэдний айх зууралдсан сэтгэл хүчтэй байдаг. Тэд зодуулж их өвдөхдөө "Ёо ёо! Ээж ээ!" гэж уйлдаг. Тэд энэ хэлмэгдлийг энгийн хүмүүс дундын хэлмэгдэл гэж үздэг. Тийм байхад намайг туслах гэж оролдоход тэдгээр хуучин хүчнийхэн хүлээн зөвшөөрдөггүй, тэд хуучин сансар орчлонгийн зарчмыг баримталдаг, сансар ертөнцөд ганц л ийм ёс байдаг гэж үздэг, шинэ сансар ертөнцийг харж чадахгүй. Тэд ингэж хэлдэг: "Энэ чиний шавь уу? Тэр чамайг Багшаа гэж үзэж байна уу? Тэр өөрийгээ бясалгагч гэж үзэж байна уу? Түүнд зөв ариун бодол байна уу? Амьдрал ба үхлийн бодлоосоо салж чадаагүй биш үү? Тэр алмааз адил хатуу бат зогсож чадаж байна уу?" Тэдний ингэж шүүмжлэхэд Багш-д үнэхээр хариулах үг байдаггүй. Мэдээж, нэг хоёр удаа юмуу эсвэл нэг амьдралдаа гаргасан хандлагаар нь тэр миний шавь биш гэж би хэлж чадахгүй. Тэд үүнийг мэднэ, тэгээд хэлдэг: "Бид түүний зөв бодлыг гаргахын тулд зоддог. Харж байгаа биз, тэр чамайг Багшаа ч гэж үзэхгүй байна. Өөртөө ч Дафа-гийн сурагч гэж хандахгүй байна" гэдэг.

Тиймээс Багш нь заримдаа юу ч хэлж чадахгүй үлддэг. Гэхдээ сансар ертөнц Фа цэвэрлэгээнд орж байгаа болохоор би энэ хэлмэгдлийг жоохон төдий ч хүлээн зөвшөөрдөггүй. Би тэдгээр харгис муу амь бодийг болон тэднийг удирдан ашиглаж байгаа Бурхдыг бүр мөсөн цэвэрлэж чадна. Тэдний түвшин хэр өндөр ч байсан, хэн зодсон, хэн удирдсан, хэн бусдыг ашигласан, эсвэл хэн зохион байгуулсан ч байсан хамаагүй би тэднийг нэг гараараа шүүрч аваад устгаж чадна. Багш энд яг энгийн хүн шиг сууж байна, намайг зүгээр нэг энгийн хүн шиг үз. Харин өөр орон зайд байгаа Багшийн биес зүйрлэхийн аргагүй том, дараагийн дараалсан болгон нь улам том, сансар ертөнц хэр том байсан ч надаас том биш. (*Алга ташив*) Гэхдээ та нар боддоо, хэрэв би тэдгээр амь бодийг устгавал сансар ертөнцийн агуу гадаргуйн давхаргуудад орших Фа цэвэрлэгээнд орж амжаагүй хуучин зарчим болон амь бодиуд бүгд үүнийг хараад "Чи юу хийж байгаа юм?" гээд бүгд довтолно, миний эсрэг хүчээ нэгтгэнэ. Тэгсэн ч би тэднийг хичнээн олуулаа байсан ч устгаж чадна, тэднийг арчин хаяж чадна, тэднийг бүтээлийн орон түвшингөөс нь буулгаж там руу унагаж чадна. Гэхдээ та нар бодоод үз, би бүх амь бодийг аврахаар ирсэн.

Тэдгээр Бурхад бас амь бодь биш үү? Тэд бүр дээд түвшний амь бодиуд, бүр ч аврах ёстой амь бодиуд. Нөгөө талаар энэ Дафа сурагч, Дафа-гийн сурагч шиг хандахгүй байхад би түүний төлөө тоолшгүй олон Бурхдыг устгаж болох уу, боддоо энэ нь зөв үү? Үгүй, энэ бол буруу. Тийм учраас ийм зүйлийг шийдэхэд Багшид маш хэцүү байдаг гэж би та нарт хэлж байна. Энэ нь Багшид тийм чадвар байхгүй гэсэн үг биш, энэ бол бүх амь бодийг аврахын тулд юм. Хэрэв та нар өөрсдийгээ зөв ариун байлгавал би та нарын төлөө юуг ч хийж чадна. Хэрэв чиний ариун бодол үнэхээр баттай, хэрэв чи амьдрал үхлийн бодлоосоо ангижирч чадвал, гуйвшгүй очир алмааз лугаа бат байвал тэдгээр адгийн муу амь бодиуд чамд хүрч зүрхлэхгүй. Яагаад гэвэл тэд чамайг алахаас өөрөөр хэлмэгдүүлж чадахгүйгээ мэднэ, тэгээд чамайг зүгээр орхихоос өөр арга тэдэнд байхгүй. Хэрэв ийм байхад тэд чамайг хэлмэгдүүлж зүрхэлбэл Багш тэднийг өршөөхгүй. Багшид тоолшгүй олон Номын биес байгаа, мөн тоолшгүй олон ариун Бурхад надад тусалж байна, тэд харгис хүчнийг бас шууд устгаж чадна. Урьд би та нарт Дафа-гийн сурагч болгоны ард Тэнгэрийн хууль сахиулагч найман төрлийн хамгаалагч байдаг гэж хэлсэн биз дээ? Тэд чамд үнэхээр туслахыг хүссэн ч чи сайн байгаагүй учраас тэдгээр Бурхдууд хуучин сансар ертөнцийн хууль дагуу хориотой байдаг.

Би хуучин хүчинтэй яг ямар хамааралтай вэ? Би энэ талаар ярья. Шууд хэлбэл энэ хуучин хүчин Фа цэвэрлэгээг устгах гээгүй, тэд устгаж зүрхлэхгүй. Тэдний зорилго ариун бус ч гэсэн бас Фа цэвэрлэгээг амжилттай дуусгахын төлөө, гэхдээ тэд энэ бүгдийг өөрсдийн шаардлаганд нийцүүлэх, Фа цэвэрлэгээг тэдний шаардлага дагуу явуулахын төлөө юм. Үүнийг туйлаас зөвшөөрөхгүй. Яагаад гэвэл сансар ертөнцийн бүх амь бодь доройтсон, тэдгээр амь бодийн бүтсэн үндсэн элементүүд хүртэл ариун бус болсон, тэр байтугай тэдгээр элементүүдийг бүтээсэн элементүүд нь хүртэл ариун биш болсон. Тэд үүнийг өөрсдөө мэдрэхгүй, тэд юу ч хийсэн гэсэн өөрсдийгээ дахин жинхэнэ ариун болгож чадахгүй. Тэд шинэ сансар ертөнцийн Фа цэвэрлэгээний шаардлаганд нийцэхгүй байж яаж Фа-г цэвэршүүлэх юм? Фа цэвэрлэгээ тэдний шаардлага дагуу явагдаж яаж болох юм? Хэрэв Фа цэвэрлэгээний дараа шинэ сансар ертөнц хуучин сансар ертөнцийн амь бодиудын шалгуур, шаардлагын дагуу бүтээгдвэл энэ нь бас л хуучин сансар ертөнц хэвээр үлдэх юм биш үү? Тэгвэл үндсэн асуудлыг нь шийдэхгүй зөвхөн хэлбэрийг нь өөрчилсөн хэрэг болох бус уу? Хуучин сансар ертөнцийн аль ч амь бодь анхны сансар ертөнц ямар цэвэр ариун байсныг мэдэхгүй, тэдний арга замаар яаж тэр хамгийн ариун, зөв байдалд хүрч чадах юм? Тийм учраас би тэднийг хүлээн зөвшөөрдөггүй. Гэхдээ тэд хуучин сансар ертөнцийн үүсэл, тогтворжилт, доройтол, устах гэсэн Фа хууль дагуу устгагдахыг хүсэхгүй, тэгээд зөн билгээрээ өөрсдийгээ аврахыг хүсч байна. Сансар ертөнцийн хамгийн дээд түвшнөөс хамгийн доод түвшин хүртэлх амь бодиуд энэ бүхнийг хамарсан иж бүрэн системд оролцож байна. Давхар бүрийн амь бодийн хорин хувь нь оролцож байна, давхар бүрээс надад Фа цэвэрлэгээ хийхэд яаж туслахыг тодорхой төлөвлөсөн. Гэхдээ давхарга давхаргын амь бодиуд нэг ч амь бодь үлдэхгүй бүгд ариун бус болсон. Тэд надад тусалж байхдаа өөрсдийгээ бодсон, амиа хичээсэн бодлоо нуудаг. Тэд бусдыг л өөрчлөхийг боддог, харин өөрсдийгээ биш. Хэн нь ч өөрийгээ өөрчлөхийг боддоггүй, тэр ч байтугай өөрсдийнхээ салж чаддаггүй зууралдсан зүйлсээ аль болохоор авч үлдэхийг боддог. Тэд энэ явцад маш олон зүйлийг муу хийсэн, зарим зүйлийг санаатайгаар хийсэн, зарим зүйлийг муу гэж ухааралгүйгээр хийсэн. Тиймээс тэдний хийсэн болгон шинэ сансар ертөнцийн шаардлаганд нийцэхгүй, хуучин сансар ертөнцийн өнөөгийн шаардлаганд ч нийцэхгүй, шинэ сансар ертөнцийн шаардлагаас асар хол, огт өөр. Тэдгээр амь бодь шинэ орчлон ертөнц ямар болох талаар огт ойлголт байхгүй. Энэ чухал үед амь бодиуд Фа цэвэрлэгээнд хэрхэн хандсанаас тэдний ирээдүй шалтгаална. Өөрөөр хэлбэл, Фа цэвэрлэгээний үед бүх амь бодь, устгагдах амь бодь хүртэл сорилтонд орж хувиарлагдана. Ийм учраас тэдэнд

шинэ сансар ертөнц ямар болохыг мэдэхийг ер зөвшөөрөхгүй. Фа цэвэрлэгээнд орох бүх зүйлс тэдний төлөвлөснөөс огт өөр.

Энэ сэдвээр ярингаа би эхлээд цаг хугацааны талаар товчхон ярья. Үнэндээ Фа цэвэрлэгээ маш хурдтай явагдаж байгаа. Сансарын биетийн гадаргуй, шинэ сансар ертөнцийн бүх зүйлс гар даллах хоромхон хугацаанд бүтээгдэж болно. Хэдийгээр энэ нь харьцангуй төсөөлөл боловч үнэхээр гараар даллах агшинд хийгдсэн, маш хурдан. Тэгвэл би үүнийг хийхэд яагаад арав гаруй жил болж байна вэ? Учир нь, сансар ертөнцөд өөр өөр орон зайнууд оршдог, орон зай болгонд өөр өөр цаг хугацаа байдаг. Сансар ертөнцөд хамгийн томоос жижиг хүртэл, туйлын микрокосмоос туйлын макрокосм хүртэл тоо томшгүй олон ширхэг хэсгүүд байдаг, тийм ширхэг болгон дээр бие даасан цаг хугацаа байдаг, цаг хугацаа бүрийн үргэлжлэх урт өөр. Тэгвэл ширхэг хэсгүүдээс тогтсон янз бүрийн хэмжээт ертөнц болгон дотор цаг хугацаа байдаг, тоо томшгүй олон ширхэг хэсгүүдээс бүтсэн сансарын асар том биетүүд дотор хүртэл цаг хугацаа оршдог. Мөн ижил түвшингийн ширхэг хэсгүүдийн асар том бүлэг бүхэлдээ бас бүр агуу том цаг хугацаатай байдаг. Энэ сансар ертөнцөд тоолшгүй олон амь бодь байдгийн адил маш олон өөр өөр цаг хугацаа оршдог. Мөн сансар бүхэлдээ өөр цаг хугацаатай, дотроо өөр өөр орон зайд тодорхой нөлөөтэй тоо томшгүй олон цаг хугацааг багтаадаг. Энэ бүх цаг хугацаа нь өөр өөр орон зайн амь бодийн оршин тогтнох байдалд зохицуулан бүтээгдсэн. Тиймээс зарим орон зайн цаг хугацаа маш хурдан байхад зарим орон зайн цаг хугацаа их удаан байдаг. Миний саяхан хэлсэн үг өөр өөр орон зайд өөр өөр хурдтай. Энэ нь зарим орон зайд ярьж эхлэхээс одоог хүртэл өнгөрсөн цаг хугацаа нь миний энд ярьж байгаатай ижил хурдтай байхад зарим орон зайд аль хэдийн болоод хэдэн өдөр өнгөрчихсөн, зарим орон зайд аль хэдийн хэдэн арван мянган жил өнгөрчихсөн, зарим орон зайд хэдэн зуун сая жил өнгөрчихсөн, эсвэл хэдэн мянган тэрбум жил өнгөрчихсөн байх жишээтэй тийм хурдан. Яагаад гэвэл сансар орчлон бол хязгааргүй уудам, түүн дотор орших ширхэг хэсгүүд нь туйлын микрокосм ба туйлын макрокосм, тэд бүгдэд өөрийн гэсэн цаг хугацаа байдаг. Хэрэв Фа цэвэрлэгээний хурд сансар орчлон доторхи цаг хугацааны бүх ухагдахуунаас давсан бол, бүхнээс гадуур хийгдвэл, хэрэв энэ нь ямар ч тухайн цаг хугацаанд хязгаарлагдаагүй сансар орчлонгийн гаднах цаг хугацаанд хийгдсэн бол, энэ нь сансар орчлон хэр том байсан ч, хичнээн олон өөр өөр цаг хугацаа байсан ч сансарын биетийн гадна гар даллах агшинд болж дуусна. Тэр хурд сансар орчлонгийн хамгийн хурдан цаг хугацаанаас ч хурдан. Гэхдээ та нар бодож үзсэн үү? Гар даллах хугацаанд зарим газруудад аль хэдийн хэдэн зуун сая жил өнгөрсөн.

Энэ хүмүүний орон зайд бас ч гайгүй Фа цэвэрлэгээ эхэлснээс хойш дөнгөж арав гаруй жил өнгөрч байна. 1999 үны 7 сарын 20 оос хойш хоёр гаруйхан жил өнгөрлөө, цаг тооллын хуанлийгаар 4 дэх жилдээ орлоо, миний Фа цэвэрлэгээ зөвхөн арав гаруй жил явагдаж байна. Боддоо, энэ нь хурдан биш үү? Үнэндээ тун хурдан, энэ бүгд гараар нэг даллах агшинд хийгдсэн, харин хүмүүний орон зайд бол арав гаруй жил болж байна. Үүнээс гадна Фа цэвэрлэгээ эхэлснээс хойш сансар орчлонгийн ерөнхий цаг хугацаа хурдасгагдаж байгаа. 1999 оны 7 сараас өмнөх нэг секунд хугацаа бүтэн нэг өдөртэй тэнцэх болсон. Одоо бүр хурдассаар байгаа. Урьдны нэг секундтэй тэнцэх хугацаа одоо бүтэн нэг жилтэй адил болсон. Энэ бол дундаж хэмжээ, энэ нь үүнээс ч илүү хурдассаар байна.

Та бүхэн боддоо, энэ хурдыг чиний бүх амьдралын түүхтэй, эсвэл чиний мөнхийн оршихуйтай харьцуулбал юу ч биш. Ирээдүйд энэ цаг үеийг эргээд харвал зөвхөн хоромхон хугацаа, юу ч биш байсныг ойлгоно. Энэ хавчлага хэлмэгдлийн эхэнд та нарт нэг өдөр жил шиг

удаан санагддаг байсан. Саяхан хүртэл олон сурагчид "Хэзээ дуусах юм бол? Энэ хэлмэгдэл хэдийд төгсөх юм бол?" гэж гайхширсаар байна. Зарим хүн, Багш шүлэгтээ хавар ирж байна гэж бичсэнийг уншаад "Оо, энэ нь хавар дуусах юм байна" гэж бодсон (*бүгд инээлдэв*). Би бас шүлэгтээ намрын тухай дурьдсан, (*бүгд инээлдэв*) тэгэхэд зарим нь "Энэ нь намар дуусах ёстой юм байна" гэж бодсон. Намар өнгөрөхөд бас л дуусаагүй, тэгээд тэдний урам нь хугарсан. Боддоо, үүнийг энгийн хүний бодлоор харж байгаа юм биш үү?

Хэрэв нэг хүн эсвэл хоёр хүн ингэж бодвол эсвэл магадгүй гурван хүн ингэж бодвол нэг их асуудалгүй. Харин Дафа сурагчид бүгдээрээ юмуу эсвэл олон хүн ингэж бодвол хүчтэй зууралдсан сэтгэл, том саад бэрхшээл биш гэж үү? Энэ цаг үеийг жинхэнэ ашиглахын оронд чи хурдан дуусахыг хүлээж сууна. Боддоо, хэрэв бид өнөөдөр дуусгавал хичнээн их хүн Хятадад устах вэ? Маш олон хүн бүр том сансарын биетүүдийн маш их амь бодиудтай холбоотой, тэгвэл энэ нь нэн даруй төгсвөл хичнээн их хүмүүс устгагдах вэ? Хэрэв тэдний толгойд байгаа сансар ертөнцийн Аугаа Фа-гийн эсрэг дайсагнасан харгис бодлыг бид зайлуулж чадахгүй бол тэдний их олон хүн аугаа сансарын биетүүдийг төлөөлдөг, тэгвэл тэдгээр хүмүүс уствал тэдэнтэй холбоотой орчлон ертөнцүүдийн хичнээн олон амь бодь үхэх вэ? Та нар хичнээн их амь устахыг ойлгож байна уу? Энэ талаар бодож үзсэн үү? Та нар Дафа-гийн сурагчид, түүх та нарт аугаа хариуцлага хүлээлгэсэн. Бид энэ цаг хугацааг сайн ашиглах хэрэгтэй. Энэ хараахан дуусаагүй байгаа болохоор хүмүүсийг, амь бодийг аврах боломж өшөө байна. Зөвхөн богинохон хугацаа үлдлээ, Фа цэвэрлэгээ хүмүүний ертөнцөд эхлэнгүүт хүмүүсийн хуваарилалт тавигдана. Бид хуучин хүчний зохицуулалтыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа ч гэсэн энэ цаг хугацаанд та нар өөрсдийгээ хатуужуулж Дафа сурагчийн агуу буяны суури тависан. Дафа-г хэлмэгдүүлж байхад Дафа сурагчдын нэгдүгээрт бодох зүйл бол: хүмүүсийг аврах, яаж Дафа-г сурталчлан таниулах асуудал юм. Энэ нь гайхамшигтай бус уу? Бид харгис хүчний төлөвлөгөөг жоохон ч хүлээн зөвшөөрдөггүй, гэхдээ эцэст нь хэлмэгдүүлэлт эхэлсэн, үүний дараа тэд маш олон хүмүүсийг хэлмэгдүүлсэн. Хамгийн түрүүнд бид энэ цаг мөчийг яаж сайн ашиглаж хүмүүсийг аврахыг бодох хэрэгтэй биш үү? Үүнийг энгийн хүмүүс нэгнийхээ эсрэг хийж байгаа хэлмэгдүүлэл мэт үзэн энгийн хүний бодлоор бодно, "Хэзээ тэд манай нэрийг сэргээх юм бол? Хэзээ энэ дуусах юм бол?" - боддоо Дафа сурагчид ийм бодолтой байж болох уу?

Хэр удаан үргэлжлэх бол гэж санаа зовох хэрэггүй. Би та нарт хэлэхэд Христүүд гурван зуун жил хэлмэгдсэний дараа дээшилж ирсэн. Ийм чухал зорилготой Дафа сурагч энгийн бясалгагчаас илүү биш гэж үү? Бид үүнийг яаж ойлгох нь маш чухал. Би та нараас асууя, хэрэв өшөө арван жил бүх хүмүүсийг аврах үйлс үргэлжилбэл та нар хийх үү? (*Сурагчид хамт хариулав, "Тэгнэ!"*) (*Алга ташив*) Дафа сурагчид ийм л байх ёстой. (*Алга ташив*) Мэдээж, дахиад арван жил байхгүй, тийм удаан үргэлжлэхийг зөвшөөрөхгүй, тэдний амьдралд тийм их цаг хугацаа үлдээгүй.

Дафа сурагчид үүнийг яаж харах нь чухал. Хэрэв ганц хоёр хүн ингэж бодож байгаа бол асуудалгүй. Хэрэв бүх Дафа сурагчид ингэж бодож байвал болохгүй. Та нар 1999 оны 4 сарын 25 аас өмнө Хятадын ерөнхий сайд Дафа-гийн талаар эерэг зүйл хэлж байсныг санаж байна уу? 4 сарын 25нд манай сурагчид засгийн газарт мэдүүлэг хүргэхээр очиход тэр зарим Дафа-гийн сурагчидтай уулзаж нааштай хариу өгсөн. Хэлмэгдэл эхэлсний дараа энэ нь манай зарим сурагчдад энгийн хүний бодол гарахад нөлөөлсөн, зарим нь бодсон: "Хятадын эх газрын харгис тэргүүн хурдан үхээсэй. Засгийн эрхээс тэр бууж оронд нь ерөнхий сайд гараасай. Ерөнхий сайд засгийн эрхэнд гарчихвал бидний нэр сэргэхгүй гэж үү?" Чи ингэж бодож үзсэн үү: Энэ бол сансар ертөнцийн Фа, хэрэв энгийн хүмүүс довтолхыг хүсвэл зүгээр довтолж чадах уу? Хэрэв

энгийн хүмүүс шударга үнэнийг сэргээхийг хүсвэл тэд сэргээж чадах уу? Энэ нь хүний хийх зүйл биш! Чи энгийн хүнд яаж найдвар тавьж болох юм? Та нар бол Дафа-гийн шавь нар! Дафа-гийн шавь болгон агуу том орон зайг төлөөлж байгаа. Хүмүүн юу чадах юм? Хуучин хүчин зөвхөн тэднийг ашиглаж байгаа юм, мөн чиний ер бусын том чадваруудыг түгжсэн. Чи үүнийг ингэж бодож яаж болох юм? Та нар бүгдээрээ ингэж бодож байвал хуучин хүчин хараад бодно: "Яахлаараа бүгд ийм бодолтой байдаг юм? Тийм бодлыг арилгах хэрэгтэй, тэр ерөнхий сайдыг муу болгочихъё." Тэд, та нарын энгийн хүний бодлыг арилгахын тулд түүнийг муу болгоно. Ингэх нь тэгвэл зөв үү? Хуучин хүчин хүний амийг харж үзэхгүй, тэд устгахыг хүсвэл шууд л устгачихна. Фа цэвэрлэгээний үед тэд зөвхөн өөрийн төлөвлөгөөг л баримталдаг.

Хэрэв Фа цэвэрлэгээ үнэхээр сүйтгэгдвэл сансар ертөнц оршихоо болино, хуучин хүчин бас устана, нэг ч амь бодь үлдэхгүй, бүх зүйл сөнөх болно. Хуучин хүчин сансар ертөнцийг шинэчлэхийг хүсч байгаа ч гэсэн тэд үнэн хэрэгтээ үүнийг хийж гүйцэтгэж чадахгүй. Тэд өөрсдийнхээ юу хийх хүсэлдээ зууралдчихсан, мөн Фа цэвэрлэгээг удирдан явуулах үүрэг гүйцэтгэх хүсэл нь зуун хувь муу. Фа цэвэрлэгээнд учруулж байгаа бүх саад бэрхшээлийг тэд зохион байгуулсан, тэдний хүссэн төлөвлөгөө ёсоор хийгдэхгүй бол тэд муу зүйл хийдэг. Фа цэвэрлэгээнд тэдгээр амь бодь арчигдана. Та нар үнэнийг таниулж байхад зарим хүн үнэхээр аврагдахад хэцүү болохыг харж байгаа. Үнэндээ дэлхийн маш олон хүмүүс аврагдах ямар ч аргагүй болсон гэж би хэлнэ. Миний бичсэн мөрийг санаж байна уу, "Нигүүлсэнгүй сэтгэлээр хэр олон хүн аврагдах вэ?" Дафа-гийн сурагчид үнэнийг ойлгуулах гэж хичнээн их зүдэрсэн ч би хэлбэл, үүний эцэст аврагдах боломжгүй маш олон хүмүүс үлдэнэ, тэд нар устгагдах хувь тавилантай. Хятададын эх газарт хичнээн хүн устгагдахыг би мэднэ, энэ нь тун аймшигтай, тоо нь маш их.

Түрүүн зогссон газраа буцаад очъё. Би хуучин хүчин надтай ямар холбоотой талаар ярьж байсан. Хуучин хүчин, сансар ертөнцийн үүсэл, тогтворжих, доройтох, устах гэсэн Фа зарчмын дагуу төгсгөлийн үедээ ирнэ гэдгийг харсан. Өөрсдийгээ аврахын тулд тэд үүнийг их эрт үеэс төлөвлөсөн. Намайг хэн болохыг хэн ч мэдэхгүй. Би хэн болохоо өөрөө ч мэдэхгүй. Ямар ч амь бодь намайг харж байгаагүй, ямар нэгэн нэрээр намайг хэзээ ч дуудаж байгаагүй. Надад нэр, хэлбэр дүрс байхгүй, би сансар ертөнцийн аль ч амь бодийн тогтсон бүх зүйлээс өөр. Сансар ертөнцийн амь бодийн хувьд ярьвал надад юу ч байхгүй, магадгүй сансар ертөнц байхгүй болсон ч зөвхөн би байж л байна. Надад юу ч байхгүй. Ямар ч амь бодь намайг хэн болохыг мэдэхгүй. Гэхдээ надгүйгээр сансар ертөнц оршин тогтнож чадахгүй. Миний энд ирсэн зорилго бол сансар орчлон ертөнц устах үед Фа цэвэрлэгээнд бүх амь бодийг аврах явдал юм.

Үнэндээ хуучин хүчний хийсэн бүх зүйлс сансар ертөнцийн амь бодиуд өөрсдийгээ аврахын тулд хийдэг төрөлх зөн билиг юм. Гэхдээ энэ нь үр дүнгүй. Сансар орчлонгийн төгсгөл ирэх болгонд тэр цаг үеийн амь бодиуд бүгд бас хийдэг байсан, гэхдээ задран устах явцыг улам түргэсгэдэг байсан. Өөрөөр ярьвал Фа цэвэрлэгээний үед бүх амь бодиуд Фа цэвэрлэгээнд өөрийнхээ хандлагыг үзүүлдэг, энэ нь тэдний үлдэх эсэхийг тодорхойлдог, Фа цэвэрлэгээнд хэр сайн хандсанаар үнэлэгдэж хуваарилагддаг. Энэ бол үүсэл, тогтворжилт, доройтол, усталтын төгсгөлийн үе дэх амь бодиудын зөвхөн үзүүлбэр. Намайг сансар ертөнцийн дунд доод түвшинд шууд гарч ирэхэд сансар ертөнцийн дээд түвшний амь бодиуд харсан. Үл оршихуйгаас би өөрийгээ хуримтлуулж бий болсон, гэхдээ жижиг хэсгүүдээс бүрдээгүй, надад жижиг хэсгүүд байхгүй. Та нар мэдэх үү, би хүмүүний оршин буй энэ газарт нэг алхалтаар ирээгүй, тэгж болохгүй. Хэрэв хэн нэгэн маш бичил жижиг хэсгээс бүтсэн бол орчлон ертөнцийн бүх зүйлд

нөлөөлнө. Өөрөөр хэлбэл амь бодийн түвшин ямар байсан ч хамаагүй доод түвшний ертөнцөд орж ирвэл тэр ертөнц задран устана. Яагаад гэвэл матери улам микрокосм болох тусам улам их энергитэй, улам их цацраг идэвхт чанартай. Гэхдээ Бурханы энерги оюун ухаантай, нигүүлсэнгүй ч гэсэн бүхнийг өөрчилчихнө. Тиймээс түвшин түвшнээр доошилж төрөл олох хэрэгтэй, тэр түвшний ширхэг хэсгээс тогтсон гадаргуйтай болоход тэр түвшинд байж болно. Гэхдээ та нар боддоо, тэгвэл үүнд асар урт хугацаа шаардагдана. Би ингэж л шат шатаар бууж ирсэн. Би ганцаар биш сансар ертөнцийн олон Бурхдууд хүний орчлонд бууж ирсэн, тэд бас шат шатаар ингэж бууж ирсэн.

Сансар ертөнцийн янз бүрийн түвшнээс маш олон Бурхадууд бууж ирсэн, тэд сансар ертөнцийг аврах зорилготой ирсэн. Хүмүүний хувьд тэд асар дээд түвшнийх. Тэд бүгдийг аврахаар тангарагалсан, тэдний их олон нь бууж ирсэн. Тэдний анхны зорилго нь сайн байсан, гэхдээ хийж чадаагүй. Тэд үүнийг хийж чадаагүй төдийгүй буцаж чадахгүй болсон. Үнэндээ, хэн байх нь хамаагүй Гурамсан ертөнцөд орж ирвэл үүрд буцаж чадахгүй болдог. Хичнээн олноороо ирсэн ч хэн нь ч хийж чадахгүй байгааг орчлон ертөнцийн хамгийн дээд түвшнийхэн харсан. Тэд бас намайг харж байсан, тэд дээрээс тодорхой харсан- "Аан, энэ хийж чадах юм байна." Тэд миний бүтэц сансар орчлонгийн бүх бие бодиос өөр, миний үндсэн мөн чанарыг юу ч өөрчилж чадахгүй гэж бодсон, тэгээд намайг сонгохоор шийдсэн. Үнэндээ маш олон Бурхадууд Дэлхийд ирсэн.

Тэд намайг сонгосон ч намайг жинхэнэ хэн болохыг мэдээгүй. Би яагаад одоо хүртэл тэдний түүхэнд зохицуулсан төлөвлөгөө дагуу зарим зүйлийг хийсээр байна вэ? Яагаад гэвэл их чухал асуудалтай холбоотой. Би саяхан Дафа сурагчдын дунд гурван хэсэг бүлгийн хүмүүс байдаг гэж ярьсан, нэг хэсэг нь надтай хувь тавилангийн холбоо тогтоохоор ирсэн. Энэ хэсэгт багтах Дафaгийн сурагчид маш олон. Тэд алс холын сансарын биетүүдээс хувь тавилангийн холбоо тогтоохоор ирсэн ба асар холын агуу том сансарын биетүүдийн маш олон амь бодиудыг төлөөлдөг. Тэдгээр амь бодь Фа цэвэрлэгээ энд явагдах учраас хувь тавилангийн холбоо тогтоох төлөөлөгч болгон тэднийг Дэлхий рүү явуулсан. Би үүнд оролцохгүй бол боддоо, сансар орчлонгийн дээд түвшний тэдгээр амь бодь өөр нэгнийг хувь тавилангийн холбоо тогтоохоор сонгож авна, мөн алсын сансарын биетүүдийн Бурхадууд хэн нэгнийг хувь тавилангийн холбоо тогтоолгохоор сонгох болно. Энэ бол жижиг зүйл биш. Хэрэв хуучин хүчин өөр нэгнийг сонгон орчлон ертөнцийн түвшин болгоныг шинэчлэхийн тулд бүх зүйлийг нарийн төлөвлөвөл тун аюултай асуудал үүснэ. Тэгвэл тэд буруу хүнтэй хувь тавилангийн холбоо тогтоосон болохгүй гэж үү? Тийм болсон ч миний Фа цэвэрлэгээнд саад болж чадахгүй байсан. Гэхдээ ноцтой асуудал гарна: аврах цаг эхлэхэд тэдний сонгосон хүн үүнийг хийж эхэлнэ, тэгсэн ч тэр хийж чадахгүй, тэр хооронд би жинхэнэ Фа цэвэрлэгээг эхлүүлнэ. Тэгвэл намайг тэдэнд саад болж байна гэж үзнэ, тэгээд хуучин сансар ертөнцийн бүх амь бодийг намайг устгахын тулд дайчилна. Тэд намайг тэдний үйл хэргийг бусниулагч гэж үзэх нь дамжиггүй, тэгээд намайг устгахыг оролдоно. Гэхдээ хэн ч намайг устгаж чадахгүй, хэн ч миний Фа цэвэрлэгээнд саад болж чадахгүй. Тэгвэл боддоо, юу болох вэ? Фа цэвэрлэгээний хурдад саад гарч огт болохгүй, хэрэв тэд надад саад хийвэл би тэднийг устгана. Тэд хоромхон зуур устгагдана, тэд хичнээн олуулаа байсан ч бүгд устгагдана. Тэгвэл боддоо, би бүх амийг аврахаар ирсэн бус уу? Тэд бүгдээрээ уствал би хэнийг аврах юм? Тийм учраас урьд түүхэнд тэд намайг сонгоход тэднийг аврах үүднээс татгалзаагүй, өөрийгээ хэн болохыг ч тэдэнд мэдүүлээгүй, мэдүүлж болохгүй. Тэд сансар орчлонгийн бүх зүйлийг болон хүн төрөлхтөний түүхэнд болсон бүх зүйлийг оролцуулан ингэж л төлөвлөн зохицуулсан. Фа цэвэрлэгээ эхлэхэд энэ нь тэдэнд бас сорилт болог гэж бодож байсан. Тэдний хийсэн бүх зүйл шинэ сансар ертөнцийн шалгуурт нийцэхгүй учраас би тэдний хийж

байгаа бүхнийг тоглоом шиг үздэг. "Хэрэв та нар тоглохыг хүсвэл, би бас тоглоно" Тэгээд л болоо. Жинхэнэ Фа цэвэрлэгээ юу вэ гэвэл өөр асуудал. Тэдэнд шинэ сансар ертөнц ямар болохыг мэдэхийг огт зөвшөөрөхгүй. Фа цэвэрлэгээнээс ямар ч амь гадуур үлдэхгүй. Тэд намайг сонгосноо намайг аврагдахад их хувь нэмэр үзүүлсэн гэж боддог. Фа цэвэрлэгээний дараа сансар орчлонг ямар болгох нь тэдний ямар болгохыг хүссэнээр хийх, юу хадгалж үлдээх нь тэдний юуг үлдээх хүслийн дагуу болгохын төлөө юм. Бодоод үзэцгээе, хэрэв сансар ертөнцийг нэг шижир алт гэж үзвэл, ариун бус амь дотор нь орвол шижир алт биш болно биз дээ? Тэгэхийг яаж зөвшөөрөх юм? Ямарч амь бодь Фа цэвэрлэгээнээс зугтаж чадахгүй, хэн ч чадахгүй. Сансарын биет, орчлон ертөнцийн бүх зүйлс үүний нэг хэсэг. Хуучин хүчин яаж ч төлөвлөж байсан хамаагүй, төлөвлөж л байг, харин төгсгөлийн үед тэдний шаардлагын дагуу хийж яасан ч болохгүй. Хуучин хүчин намайг тэдний төлөвлөгөөг дагах шахалт үзүүлснээс өнөөдөр энэ саад бэрхшээлүүд гарч ирсэн. Ямар ч хэцүү саад бэрхшээл үзүүлсэн миний Фа цэвэрлэгээний шинж чанарт нөлөөлж чадаагүй. Мөн явц нь бас хурдан, энэ нь ялгаагүй миний шаардлагын дагуу явагдаж байгаа-шинэ сансар ертөнц бүх зүйлсийг Дафа-гийн шалгуур дагуу үндэслэн байгуулж байгаа. Үнэндээ хуучин хүчин Фа цэвэрлэгээ ирэхээс өмнөх энэ завсарт л үйл ажиллагаагаа явуулж өөрсдийгээ таниулж, Дафа-гийн сурагчид энэ цаг хугацаанд Фа-г дэмжин сахиж оюун ухаант амь бодийг аварч, хэрцгий адгийн амь бодиуд хуучин хүчинд ашиглагдан Дафа сурагчдыг, оюун ухаант бүх амь бодийг хэлмэгдүүлж, тэдгээр хэрцгий адгийн амь бодиор удирдуулсан муу хүмүүс бас энэ үед харгислал үйлдэж байна.

Хуучин хүчин хүмүүний орчлонд энэ зүйлийг хийхийн тулд хэр удаан хугацаанд төлөвлөсөн бэ? Хоёр Дэлхийн хугацаанд. Би түрүүн, Дафа хүмүүний орчлонд урьд өмнө дэлгэрч байсан гэж хэлсэн. Олон сурагчид надаас хэдийд дэлгэрч байсан бэ гэж асуусан? Урьд Дэлхийн үед. Яагаад? Урьдах Дэлхий бол энэ Дэлхийн туршилт байсан. Хуучин хүчин, шинэчлэх төлөвлөгөөнд нь хамгийн сүүлдээ ямар ч асуудал гарахгүй байлгах, гажуудахаас сэргийлэх туршилтыг өмнөх Дэлхийд хийсэн. Тэдэнд яагаад ийм урт хугацааны туршилт хийх шаардлагатай байсан бэ? Яагаад гэвэл Дэлхийн энэ байршил дээр хэзээ ч хүмүүн адил амь бодь оршиж байгаагүй. Би яагаад харь гаригийнхны талаар заримдаа ярьдаг вэ? Яагаад гэвэл урьд хичнээн ч удаа Дэлхий шинэчлэгдэн бий болсон, энэ байршил дээрхи Дэлхийн үндсэн амь бодь нь харь гаригийнхны хэлбэртэй байсан. Үе болгонд тэд хоорондоо их ялгаатай байсан, гэхдээ бүгд хүний хэлбэр дүртэй адил байгаагүй.

Бурхадууд түүхэнд хүнийг яагаад өөрсдийнхөө дүр төрхтэй бүтээсэн бэ? Энэ нь бясалгалын орчинд бас учир битүүлэг таавар байсан. Би та бүхэнд хэлье, яагаад гэвэл Фа-г энд заах болно, Фа сонсох оюун ухаант амь бодиуд Фа сонсоход хүндэтгэлтэй дүр төрхтэй байх ёстой. Бөөн амьтдыг энд авчраад Фа сонсговол Аугаа Фа-г гутаасан болно, тийм байхыг зөвшөөрөхгүй. Хэрэв ямар нэгэн Бурхан эндхийн амь бодийг Дафа-г дэлгэрүүлэхийн тулд биш зүгээр хүний дүр төрхтэй бүтээвэл Бурхадыг доромжилсонтой адил болох учраас бүх Бурхад түүнийг устгана. Бурхадууд Фа цэвэрлэгээ явуулахын тулд хүмүүнийг Дэлхий дээр өөрсдийнхээ дүр төрхтэйгээр бүтээсэн. Азийнхныг Ази хүмүүстэй төстэй Бурхадууд бүтээсэн, Европынхныг Барууны хүмүүстэй төстэй Бурхадууд бүтээсэн, мөн хар хүмүүстэй төстэй Бурхадууд хар хүмүүсийг бүтээсэн, бусад арьстангуудыг бас бусад Бурхадууд бүтээсэн. Тэр үед бүх хүмүүс өөрсдийгээ бүтээсэн Бурхадыг Эзэн гэж нэрлэдэг байсан. Гэхдээ одоо хүн төрөлхтөний 90 хувь нь дээд түвшнээс ирсэн, ихэнх нь маш өндөр түвшнийх. Тэд Бурхадын урьд бүтээсэн хүний арьсыг л зөвхөн хэрэглэж байгаа. Тэд үнэхээр хүмүүнийг бүтээсэн Бурхадтай шууд холбоо байхгүй. Би урьд эхний дэлхий дээр Фа-г ийм өндөр хэмжээнд заагаагүй, яагаад гэвэл тэр зөвхөн туршилтын зорилготой байсан. Тэр

заасан Фа амь бодийг зөвхөн Фалуень диваажинд аваачиж аварсан. Тиймээс тэр үед аврагдсан амь бодиуд бүгд Фалуень диваажинд байдаг. Тэр Дэлхийг эцсийн шат хүртэл оршихыг зөвшөөрсөн. Тэр үеийн шинжлэх ухаан, техникийн хөгжил маш дээгүүр байсан, сарыг тэнгэрт гаргасан үе юм. Гэхдээ өндөр хөгжсөн аж үйлдвэрээс болж агаар, ус, хөрс, хүмүүсийн хоол хүнс болон тэр үеийн бүх зүйлс хэлбэр бүтцээ алдсан. Эцэст нь хүмүүс хүртэл хувиралд орсон, Дэлхийн энергийн нөөц бололцоо бүрэн шавхагдаж дууссан, ийнхүү тэр үеийн хүмүүст төгсгөл ирсэн.

Энэ Дэлхийн үе 100 сая жилийн өмнө эхэлсэн. Энд байгаа та нарын зарим нь, "Гэхдээ би сурах бичгээс Дэлхийн насыг 3.5 аас 4.5 тэрбум жил гэж уншсан шүү дээ" гэж бодож магад. Би хэлбэл, Дэлхий болгон 100 сая жил л оршдог, өмнөх Дэлхий бас 100 сая жил болсон. Гэхдээ Жуан Фалуень-д би бас археологийн үлдэгдлээс Дэлхий хэдэн зуун сая жил, зарим судалгаагаар 2 тэрбум жил үргэлжилсэн гэж бичсэн. Үүгээр би хүмүүст зөвхөн өмнөх соёл иргэншлийн үе байсан гэдгийг л хэлсэн. Хүмүүнд зөвхөн энэ хэмжээнд мэдэхийг зөвшөөрнө, мөн энэ 100 сая жилийн хугацаанд хүн төрөлхтөн маш олон удаа түүхийн өмнөх соёл иргэншлийг бүтээсэн. Урьд Дэлхийн байран дээр байсан гаригууд бас олон удаа устаж, дахин бүрдэж байсан. Сансар ертөнцөд маш олон гаригс устан задарч байдаг, тэр үлдэгдэл хэлтэрхийнүүд нь энд тэндгүй хөвөн хоорондоо холилдож тоосонцор, од маягийн жижиг биетүүдийг үүсгэдэг. Сансарын агуу биет дотор гаригс тасралтгүй задран устаж бас шинээр бүтээгдэж байдаг, эдгээр нь дэлбэрэлтээр задран устдаг. Дэлхий бас үүний адил бүтээгдсэн, өмнөх Дэлхийнүүдийн дэлбэрэлт, дахин дараачийн Дэлхийнүүд үүсэх гэх мэтээр нэг нь дэлбэрэхэд дараагийнх нь үүсдэг замаар явж ирсэн. Огторгуйд маш их тоосонцорууд байдаг, зарим нь маш том, зарим нь том чулуу шиг, зарим нь хэдэн хавтгай дөрвөлжин км том талбайтай, зарим нь бүр 100 хавтгай дөрвөлжин км том хэмжээтэй байдаг. Гариг болгон дээр соёл иргэншил байсан, өмнөх Дэлхийнүүд дээр бас соёл иргэншил байсан. Дэлбэрэлтэнд бүтэн устгагдаагүй үлдсэн олон том хэсгүүд дээр урьд оршин суугчдын соёл иргэншлийн үлдэгдэл байдаг. Дэлхийг энэ сансар ертөнцийн тооснуудыг нэгтгэж бүтээдэг учраас дээр нь өмнөх Дэлхий болон өөр гаригуудын түүхийн олдвор, соёл иргэншлийн үлдэгдлүүд байдаг. Өнөөдөр би үүнийг илчлээгүй бол геологчид болон түүхчид ямар ч арга хэрэглээд энэ Дэлхийн материалуудыг аль үеийнх болохыг тогтоож чадахгүй байхсан. Би сая хэлсэн, энэ Дэлхий 100 сая жилийн түүхтэй, өнөөг хүртэл тоолбол яг 100 сая жил, энд урьд байсан Дэлхийн настай одоо адил болсон. Мэдээж энэ 100 сая жилийн туршид хүн төрөлхтөн олон соёл иргэншлийн үеийг дамжсан, зан, ёс суртахууны доройтлоос болоод Бурхдаар олон удаа устгагдаж байсан. Одоогийн хүмүүний соёл иргэншил бол хуучин хүчнээр зориуд төлөвлөгдөн зохицуулагдсан, энэ нь хүмүүний жинхэнэ соёл иргэншил биш юм.

Тэгвэл хүний арьсыг яагаад Фа заах үед, Бурхадууд Фа сонсохоор бууж ирсэн үед шууд бүтээгээгүй вэ? Яагаад хүнийг тийм эрт дээр үед бүтээсэн бэ? Бурхад хүнийг бүтээхдээ Бурханлаг ухаан бодол, үзэл санааг суулгаж өгдөггүй гэдгийг мэдэх хэрэгтэй, тэгвэл хүн биш бүхэл бүтэн бурхан бүтээсэн болно. Үүнийг зөвшөөрөхгүй. Хэдийгээр хүмүүс Бурхадтай адил харагддаг ч гэсэн Бурхадууд хүнийг өөрийн төрөл гэж үздэггүй, хүмүүсийн биеэ авч явах байдал Бурхадаас огт өөр. Тэгвэл анхны хүмүүс ямархуу байсан бэ? Бурхад хүний биеийн зохион байгуулалтыг бүтээсэн, тиймээс энэ нь энэ орон зайн хамгийн боловсронгуй бие бодийн систем. Бүх харь гаригийнхан хараад бишрэн уулга алддаг! Мэдээж үүнд бас гурван амь, долоон сүнс оршиж байж бүхэл бүтэн хүний бие болно. Гурван амь, долоон сүнсгүй бол энэ нь зөвхөн хүний биеийн гадаргуй, "хүний арьс" болно. "Хүний арьс" гэдэг ойлголт бол хүмүүсийн мэддэг арьснаас өөр. Бурхадууд хүний биеийн хамгийн гадаргуйн молекулаас тогтсон бүх зүйлийг: яс, цус, дотоод эрхтэн гэх мэт, мөн хүний биеийн гадаргуйн бүхэл бүтэц, өөрөөр хэлбэл бичил

хэмжээнд харвал молекулын эсээс бүтсэн хүний гадаргуй, задлан шинжилгээ хийхэд хүний нүдэнд харагддаг бүх зүйлсийг гадаргуйн бүхэл бүтэн бүтцийг "хүний арьс" гэж авч үздэг. Тэд хүний арьсыг хэлээгүй.

Хэрэв хүн, сансар ертөнц болон хүмүүний орчлонгийн бүх зүйлийг ойлгох чадваргүй, эсвэл амьдрал яаж тогтдогийг мэдэхгүй, мөн эрээн бараан орчлонгийн өөрчлөлтийг тэсвэрлэн даван туулах чадваргүй, ямар ч тогтсон ухамсаргүй бол, мөн сансар орчлон, дэлхий эсвэл байгаль орчингийн талаар ямар ч мэдэгдэхүүнгүй бол, дасан зохицож чадахгүй бол тэр яах вэ? Би хэлье, баяртай зүйл тохиолдоход тэр мод руу авирч гараад чанга орилон тасралтгүй инээнэ, инээх нь үнэхээр эв хавгүй аймшигтай. Хэрэв гунигтай, зовлонтой ямар нэгэн зүйл тохиолдвол тэр газарт шурган орж энэ байдлаасаа хэдэн өдрөөр гарч чадахгүй. Хэрэв тэр ямар нэгэн зүйлд уур нь хүрвэл ямар ч бодлогогүйгээр уураа юунд ч гаргана. Тэгээд тэр баярлах, уурлах, гуниглах зэрэг сэтгэл хөдлөлөөсөө болж үхэж болно. Боддоо, ийм маягийн хүн Фа сонсож чадах уу? Гэхдээ хүмүүс анх бүтээгдэхдээ ийм байсан, ямар ч зүйл тэдэнд байгаагүй, ямар ч тэвчээр байгаагүй, мөн энэ орон зайд тэдэнд юмыг хүлээн авах, төсөөлөх бүрэн бүтэн ойлголт байгаагүй. Тиймээс аажмаар хүний ухаанд тэдгээр зүйлийг суулгах, хүнийг тэвчээртэй болгоход удаан хугацаа шаардлагатай. Энэ бол богино хугацаанд хийчих зүйл биш, тиймээс 100 сая жил үүнийг хийхэд зарцуулагдсан. Одоогийн хүмүүс бол ямар нэгэн зүйл тохиолдоход ухаанаа алдахгүй болсон, тайван тэнцвэртэй байж чадна, бодлоготой хандаж чадна, тэрч байтугай зохион бүтээх чадвартай болсон. Хүн ийм ухаан, хэвийн сэтгэн бодох чадвартай болсон нь Бурхад үүнийг түүхийн их урт хугацааны туршид зорилготойгоор бий болгосны үр дүн юм. Энэ явц бол би хэлье, таван мянган жилийн өмнө дууссан.

Одоо Хятадын тэнгэрлэг-хагас бурханлаг соёл ахуйн таван мянган жилийн сүүлчийн үе, энэ үед хүний системтэй, төлөвшсөн оюун ухаан эхэлсэн нь Фа хүлээж авах боломжтой болсон. Хэдий хүмүүний орон зайн зарчим урвуугаар эргэсэн ч сансар ертөнцийн аугаа Фа ариун. Намайг Фа заахад Фа зарчмын дотоод утга санаа, үгс, илэрхийлэгдэх байдал нь Гурамсан ертөнцөөс дээших өөр түвшин болгонд өөр өөрөөр сонсогддог, гэхдээ Фа зарчим бол хэзээд тогтмол. Өөр өөр давхарга дахь өөр өөр амь бодь хоорондоо зохилдоотой байдаг. Би энд хүмүүнд нэг янзаар зааж байхад тэнгэрт өөр янзаар байвал боддоо, энэ Фа бүхнийг багтаасан байж чадахгүй, тийм байж болохгүй, Фа цэвэрлэгээнд энд хүмүүнд заасан Фа сансар ертөнцийг бүхэлд нь хамаарсан байх ёстой. Намайг Фа заахад түвшин, түвшин дэх Би бас Фа зааж байдаг, түвшин түвшингийн амь бодь Фа сонсож байдаг.

Тэгвэл хүмүүний бодлыг яаж бүрэлдүүлж, төлөвшүүлбэл Фа сонсоод хүлээн авч чаддаг болох вэ? Би яаж Фа заана, тийм байдлаар хүн төрөлхтөний соёл, хүний бодол санаа төлөвшинө. Дэлхий дахины хүмүүс ёс суртахуун гэж юу болох, итгэл үнэмшил, нинжин ба харгис гэж юу болох, юу нь сайн юу нь муу болохыг мэднэ, эдгээр бүгд бол энгийн зүйлс. Хятадад эдгээр нь илүү тодорхой харагддаг мөн дотоод утга нь ч бас гүн. Фа тэнд заагдах учиртай байсан болохоор энэ бүгд тэнд хийгдсэн, хүмүүст Фа-г жинхэнэ ойлгох хүлээн авахад шаардлагатай баялаг соёл ахуй тэнд бүтээгдсэн. Урьд та бүхэнд, би Дафа-гийн олон шавь нартайгаа түүхэнд хувь тавилангийн холбоо тогтоож ирсэн гэж хэлсэн. Хувь тавилангийн холбоо тогтоох нь зөвхөн гаднах зорилго, үүний дараа Дафа-гийн шавь нар надтай хамт Дафа-д шаардлагатай хүмүүний соёл иргэншил, ахуйг байгуулах үүрэгтэй. Ийм учраас Дафа-г заах зорилгоор бүтээгдсэн хүн төрөлхтөний түүхэнд хэрэв хэн нэгэн энгийн хүн соёл иргэншил бий болгох, түүхэнд ул мөрөө үлдээх, эсвэл онол гаргах гэвэл туйлаас зөвшөөрөгдөхгүй. Тиймээс түүхээс дамжиж ирсэн бүх

соёл ахуй нь Дафа-гийн шавь нарын бүтээл, мэдээж та нарыг удирдаж байгаа Багш нь бас байсан. Хүн төрөлхтөний түүх жүжигтэй адил, та нар эзэн хаанаас энгийн ард, баатараас дээрэмчин хүртэл (*инээлдэв*), сэхээтнээс нэртэй цуутай хүн, баатарлаг үйлстэн хүртэлх бүх дүрд тоглосон. Битгий инээлд! Хэрэв хэн ч дээрэмчний дүрд тоглохгүй бол өнөөдөр намайг Фа заахад дээрэмчин гэж хэн болох, дээрэмчний үйл хэрэг, бодол санаа мэдрэмж, эсвэл дээрэмчний төрх байдал ямар болохыг хүмүүс мэдэхгүй байхсан. Фа-д орхигдуулсан зүйл байж болохгүй.

Та нар "Гурван хаант улс" роман мэднэ биз? Тэр номонд итгэл даах гэдгийн жишээг харуулдаг. Нэг гүрний турш гурван хүчний өрсөлдөөн дунд итгэл даах гэдгийн утгыг бүрэн харуулсан. Мөн бүхэл гүрний оршин тогтсон хугацааны турш итгэл даах гэсэн үгний зан ёс үүссэн, зөвхөн үүний дараа өнөөдөр Фа заахад хүн төрөлхтөн итгэл даах гэдгийн гүн ойлголттой болсон, итгэл даах гэж юу болохыг, мөн энэ үгийн ил, далд болон өргөн гүнзгий утгыг мэднэ. Хүмүүс энэ үгийн зөвхөн ил утгыг мэдэж байх нь хангалттай биш, бас далд утгыг ойлгох хэрэгтэй. Гурван хаант улс романд бас хүний мэргэн ухаан, бусад шинж чанарыг харуулдаг.

Өмнөд Сон гүрний Юэ Фэй "үнэнч шударга" гэдгийн тод жишээг харуулсан. "Үнэнч шударга" гэж юуг хэлэх вэ? Үүнийг зүгээр нэг хэлээд жишээ дурьдахад хангалтгүй. Бүтэн нэг гүрний дараа л хүмүүс энэ үгийн талаар жинхэнэ гүн ойлголттой болсон, мөн үүний илрэх байдал, шинж чанарыг мэддэг болсон.

Түүхэнд бас хэдэн зуун гүн ухаантнууд байсан. Кунцийн алтан дундаж хэмээх зарчим байсан, түүгээр мөн хүмүүнлэг чанар, шударга ёс, ээлдэг харьцаа, мэргэн ухаан, итгэл гэх мэт ухагдахууныг заасан. Зөвхөн Шагжамуни, Лао Зи болон Есүс ирсэний дараа л хүмүүс өнөөдөр ариун итгэл бишрэл, бясалгал гэж юу болохыг жинхэнэ мэддэг болсон, мөн Будда, Дао, Бурхан гэж хэн бэ гэдгийг мэддэг болсон. Түүхийн туршид хүн төрөлхтөний мэдлэг, оюун санаа баяжиж ирсэн, энэ нь хүмүүсийг Фа таних, ойлгох, Фа олох боломжтой болгосон. Хүн төрөлхтөний түүхийн бүхий л явцад энэ суурийг тавьсан. Өөрөөр хэлбэл Дафа заахын тулд хүн болон хүмүүний соёл бүтээгдсэн, хүн төрөлхтөний соёлыг хадгалахын тулд Фа зааж байгаа юм биш, мөн Фа бол хүн төрөлхтөний соёл биш. Энэ таван мянган жилд бид үүнийг хийсэн.

Энэ сэдвээр ярингаа үүнийг улам тодруулъя: Хүний нийгэм бол жүжигтэй адил-нэг гүрний дараа нөгөө гүрэн гарч ирнэ, энэ нь яг хөшиг нээгдэж нэг гүрэн, нэг үе эхэлнэ, нэг гүрэн, үеийн төгсгөлд том хөшиг хаагдана. Дараа нь бас хөшиг нээгдэж өөр гүрэн, өөр үе эхэлж хуучин гүрэн солигдоно. Нэг гүрний дараа нөгөө гүрэн, тайзны нэг үзэгдэл нөгөөгөөр солигдох замаар ар араасаа цуварч хувь тавилангийн холбоо үүсгэсэн, ардаа түүх үлдээсэн, хүн төрөлхтөнд хэрэгтэй соёлыг бүтээсэн. Хятадад яагаад "эзэнт гүрэн" гэдэг, харин бусад газар "улс" гэж нэрлэдэг байсан бэ? Яагаад тэдний удирдагчийг хаан, Хятадад болохоор "эзэн хаан" гэж нэрлэдэг байсан бэ? Би та нарт хэлье, энэ бол зүгээр үг хэллэг эсвэл соёлын ялгаа биш. Хүн төрөлхтөн Дафа-гийн тулд бүтээгдсэн юм бол Дафа энэ жүжгийн гол сэдэв, улмаар бүх амь бодийн орших нь энэ сэдвээс хазайдаггүй. Хүмүүс энэ жүжгийн үйл явдалд гарах зөрчил, тэмцэлд автаж жүжгийн гол сэдвийг, амьдралынхаа зорилгыг мартсан. Жүжгийн тайз бол Хятад.

Гүрний дараа гүрнүүд, гүрэн болгоны хүмүүс тэр гүрний тэнгэрийн хүмүүс. Тэд алс холын сансарын биесийн төлөөлөгчид, тэнд байгаа тоо томшгүй олон амь бодийг төлөөлж байгаа бөгөөд энд хувь тавилангийн холбоо тогтоож Фа цэвэрлэгээний үед тэдгээр амь бодийг орхигдуулахгүйн тулд ирсэн. Тэдгээр гүрний үед хувь тавилангийн холбоо тогтоох явцдаа авч

ирсэн ахуй соёлоо үлдээсэн. Тэд хувь тавилангийн холбоо тогтоосны дараа, дараагийн амьдралдаа өөр газруудад төрсөөр Дафа заагдах өдрийг хүлээж ирсэн. Гүрэн болгон ийм байсан, энэ дэлхийн бүх үндэстэн ястан Хятадад төрсөн, улс болгоны хүн болгоныг хамаарна. Сүүлийн үед намайг Фа зааж эхэлснээс хойш дээд түвшнээс ирсэн олон амь бодиудаас бусад улс болгоны хүмүүс түүхийн тодорхой үед Хятадад төрсөн. Чи ямар оронд байгаа нь хамаагүй энэ дэлхийд чи анх Хятад хүн байсан, яагаад гэвэл чиний анхны төрөл энд эхэлсэн. Энэ талаар ярихдаа би та нарт хэлье, үнэндээ Хятад орон гэсэн ойлголт хэлбэр гэж байдаггүй. Ингэж хэлэхэд та нарт хачирхалтай санагдаж байна уу? Үнэндээ, Хятадын ахуй соёлыг өөр өөр гүрний үед байсан дэлхийн бүх хүмүүс үлдээсэн. Тэдгээр хүмүүс хувь тавилангийн холбоо тогтоосны дараа өөр өөр газруудад дахин төрсөн. Жишээ нь, өнөөдрийн Америк хүмүүс аугаа Мин гүрний ард иргэд нь байсан. Өнөөдрийн Америкчууд Дао-д дуртай, өнөөг хүртэл тэр үеийн уламжлалыг авч үлдсэн. Урьд Мин гүрний үед Дао-гийн шашин дэлгэрч оргилдоо хүрч байхад, зарим хотын айл бүхэнд бараг арц, хүж уйгуулах сав байсан. Англи Их Тан гүрэн, Франц Их Чин, Итали Юуань, Австрали Шиа, Орос Жоу, Швед Хойт Сон, Тайвань Өмнөт Сон, мөн Япон Сүй гүрэн байсан. Тэр үед гүрэн болгоны хүмүүс Хятадаас өөр хүн оршин суудаггүй, одоогийн улс орон байхгүй зэлүүд газруудад дахин төрдөг байсан. Бараг бүх хүмүүс дэлхий даяар тархан дахин төрж байсан, зөвхөн сүүлчийн үед анхны газартаа буцаж төрцгөөсөн. Нэг гүрний хүмүүс нэг газар луу очсон, өөр гүрний хүмүүс өөр газарт очсон, ингэж явж ирсэн. Тэгэхээр шууд хэлэхэд "Хятад" гэж хаана байна вэ? Мөн хэн "Хятад хүн бэ?" Үнэн утгандаа "Хятад" гэж оршдоггүй.

Гэхдээ одоо оршдог, тийм үү? Яагаад гэвэл одоо улс гэж нэрлэгддэг, гүрэн байхаа аль эрт больсон. Үнэндээ байхаа больсон, яагаад гэвэл сүүлчийн тайзны үед Фа заах болоход надтай хувь тавилангийн холбоо тогтоосон дэлхий дахины хүмүүс, Фа олж авах магадлал сайтай хүмүүс болон Дафа өргөн дэлгэрэхэд саад болох үүрэгтэй хүмүүс бүгд буцаж Хятадад төрсөн. Фа олж авахын тулд ирсэн эсвэл сүйтгэхээр ирсэн хэн ч гэсэн бүгд Фа-гийн төлөө ирсэн, Фа-гийн тулд төрсөн, Фа-гийн тулд оршиж байна, бүгд байраа эзэлцгээсэн. Тийм учраас өнөөгийн Хятад хүмүүс их холилдсон, дэлхийн өнцөг булан бүрээс сайн, муу хүмүүс Фа цэвэрлэгээний үед энд цуглацгаасан. Сайн ч бай, муу ч бай үүрэг гүйцэтгэхээр ирсэн байсан ч Фа цэвэрлэгээ нь хуучин хүчний зохицуулалтыг хүлээн зөвшөөрдөггүй учраас Фа цэвэрлэгээнд зөв хандвал устгагдахгүй үлдэх найдвар бас бий. Хэрэв Фа олж авбал, би түүнийг аварна. Би та нарт урьд бас нэг зүйлийг хэлж байсан. Би та нараас, энэ дэлхийд ардчилал яагаад гарах болсныг мэдэх үү? гэж асууж байсан. Үндсэн шалтгаан нь бол, тэдгээр үндэстэн ястаны хаадууд, тэдгээр сансарын биетүүдээс ирсэн бүгд Хятадад төрсөн. Тэдгээр бусад газруудад хэн өөрийгээ хаан гэж өргөмжилж чадах юм? Эцэст нь, хуучин хүчний амь бодиуд "Хүмүүс өөрсдийнхээ удирдагчийг өөрсдөө сонгог" гэж шийдсэн. Хэн нэгэн сонгогдоход Хаан гэж тэр нэрлэгдэж болохгүй. "Тэгэхээр түүнийг ерөнхийлэгч гэж нэрлэе." Удирдагч болсон ч тэдгээр хүмүүс Хаан шиг өргөмжлөгдөж чадахгүй, хэрэв муу болбол хүмүүс түүнийг муулна, бүр муу болбол огцруулна, өөр нэгнийг сонгоно. Энэ бол дээд амь бодиуд яагаад ардчиллыг төлөвлөсний жинхэнэ шалтгаан юм. Бас бусад хүчин зүйлс бий. Хүмүүний орших энэ газарт оршдог зүйлст хүний давхаргын зарчмууд бас багтдаг. Хүмүүс ямар учиртай болохыг мэдэхгүй. Өнөөгийн Хятад хүмүүс их хэмжээний нүглийнхээ улмаас нүдэнд аятайхан харагдахгүй болсон ч, энэ арьс үзэсгэлэнтэй биш болсон ч доторхи агуулагдаж байгаа зүйлс нь их гүн. Бодоод үз, хэрэв тэнд (Хятадад) байгаа амь бодь уствал ямар аюултай вэ? Тэдний төлөөлж байгаа бүх зүйлс, орон зай, тэдэнтэй холбоотой амь бодиуд бол бүгд том бүлэг хэсгүүд.

Эдгээр зүйлийг ярилаа бас өөр зүйлийн талаар хэлэхийг хүсч байна. Би сая дэлхийн түүх зөвхөн 100 сая жил үргэлжилдэг гэж хэлсэн. Энэ дэлхийн 100 сая жил үндсэндээ хоёр том үед хуваагддаг, үе болгон нь 50 сая жил үргэлжилдэг. Эхний 50 сая жилийн үед аварга хүмүүс, одой хүмүүс, мөн дунд зэргийн хэмжээний хүмүүс зэрэгцэн оршдог байсан. Аварга хүмүүсийн дундаж өндөр 5 метр байсан, дунд зэргийн хэмжээний хүмүүс одоогийн орчин үеийн хүмүүс шиг дундаж өндөр нь 2 метрээс бага, мөн одой хүмүүс нь зөвхөн хэдхэн цун хэмжээтэй байсан (1 цун = 3.33см). Бурхад хүнийг бүтээхдээ яагаад ийм гурван хэлбэрийн хүнийг зэрэг бүтээсэн бэ? Энэ нь энэ гурван төрлийн хүний аль нь сүүлчийн үе хүртэл дэлхийд амьдрахад илүү тохирох, тэгээд Фа олж авахад нийцсэн болохыг үзэх шалгаруулалт байсан. Энэ 50 сая жилийн хугацаанд хүний дэлхий орчлонг танин мэдэх чадвар байнга бүрэлдсээр ирсэн. Үүний зэрэгцээ аль хэлбэрийн хүнийг үлдээхийг шийдвэрлэсэн. Эцэст нь аварга хүн тохиромжгүй болох нь харагдсан. Тэд том биетэй учраас дэлхий дээрхи холын зай тэдний хувьд харьцангуй богино байсан. Тэд бас цаг хугацааг харьцангуй богиносгосон, учир нь тэдний материаллаг хэрэгцээ нь дэлхийн нөөц бололцоотой харьцуулахад тэнцвэргүй байсан. Дараа нь одой хүмүүс бас тохиромжгүй болох нь харагдсан, дэлхий дээр ой хөвч хаа сайгүй байсан, тэдэнд модыг цэвэрлэхэд хэцүү байсан. Тэр үед задгай газар байгаагүй учраас тэдэнд өнөөдрийнх шиг соёл иргэншил байгуулахад хэцүү байсан. Түүнчлэн одой хүмүүсийн хувьд дэлхийн цаг хугацаа хэтэрхий урт, зай хэтэрхий хол, далайг гатлах бол санахын аргагүй хол байсан. Тиймээс тэд тохиромжгүй байсан. Улмаар аварга хүмүүс, одой хүмүүс устсан. Тэд тэр дороо устаагүй, түүхээс тэд аажмаар арчигдтал 50 сая жил үргэлжилсэн. Хоёр зууны өмнөөс аварга хүмүүс дахин үзэгдэхээ больсон, өөрөөр хэлбэл хоёр зуу гаруй жилийн өмнөөс бүрмөсөн алга болсон. Одой хүмүүс 70, 80 жилийн өмнө хүртэл үзэгдсээр байсан. Зөвхөн сүүлийн үед тэд устсан, гэхдээ тэд бүрмөсөн алга болоогүй, зарим нь өөр орон зайд орсон, зарим нь газар доогуур орсон. Тэд өөрсдийгээ арчигдсан хүмүүс гэдгээ мэднэ, тиймээс тэд орчин үеийн хүмүүстэй харьцдаггүй.

Энэ сэдвээр ярингаа би өнгөрсөн үеийн хоёр нууцыг тайлъя. Хүн төрөлхтөн пирамидыг яаж барьсныг тайлбарлаж чаддаггүй. Хүмүүс яаж тийм том чулуунуудыг зөөж чадсан бэ? Үүнийг таван метрийн өндөртэй тийм хэдэн том хүмүүс зөөх нь одоогийн хүмүүсийн том чулууг зөөхтэй ялгаагүй. Таван метр өндөр хүмүүсийн хувьд тэдгээр пирамидыг барих нь өнөөдөр хүмүүс өндөр байшин барихтай адил. Өөр нэг нууц гэвэл динозавр мэтийн том амьтад яагаад байдаг байсан вэ? Үнэнийг хэлбэл, тэдгээр амьтад аварга хүмүүст зориулагдсан. Таван метрийн хүн динозавр мэтийн том амьтдыг харах нь манай хүмүүсийн үхэр харсантай ялгаа байхгүй. Өөр хүмүүст өөр өөр төрөл зүйлийг бэлдсэн. Дэлхий дээрхи бүх зүйлс хүний тулд бүтээгдсэн, хүний тулд оршиж байна. Үүний зэрэгцээ та нарт хэлэхэд, амьтдыг хүнтэй эн зэрэгцүүлж туйлаас болохгүй, адилхан үзэж огт болохгүй. Амьтанд өршөөнгүй байж болно, тэднийг арчилж хамгаалж болно, гэхдээ хүнтэй адилхан хандаж болохгүй. Бурхан хүнийг бүтээсэн, амьтдыг хүнтэй адилтган үзвэл хүнийг доромжилсонтой адил, Бурхдыг гутаасантай адил болно. Түүхийн үнэн удахгүй хүмүүст харагдана, тэр үед хүн төрөлхтөн сансар ертөнц, амь болон материйн талаар үнэн зөв ойлголттой болно. Өнөөдөр зарим хүн археологийн ажил хийхдээ хүний ясыг динозаврын ясанд залгачихдаг, мөн пирамид баригдсан талаар хүмүүс бас явцуу ойлголтондоо тулгуурлан дүгнэлт хийдэг. Үнэндээ энэ материаллаг ертөнцийн талаархи шинжлэх ухааны олон тайлбарууд буруу, анхны төсөөлөл нь хүртэл буруу. Түүнчлэн дэлхийн татах хүчний онол бас буруу. Би эдгээр зүйлийн талаар боломж гарвал ярина.

Би сая хүн төрөлхтөний түүхийг халхалсан хөшгийг нээлээ. (*Алга ташив*) Түүхийн талаар ярих гээгүй, хүн төрөлхтөн Дафа-гийн тулд бүтээгдсэн, бас оршиж байгаа учраас ярилаа. Би энэ

түүхийг ярингаа та нарт Фа зааж байна, яагаад гэвэл энэ бүгд Фа-тай холбоотой учраас. Дафа сурагчдын хувьд их олон зүйлс үнэхээр чухал, ялангуяа одоо та нарын хийж байгаа бүх зүйл бол Дафа-гийн өмнө хүлээсэн чиний хариуцлагатай холбоотой, үүнд бас Дафа сурагчдын гүн, чухал хүчин зүйлүүд багтдаг. Би та нарыг Фа цэвэрлэгээний явцад улам сайн хийнэ гэдэгт найдан энэ бүхнийг тайлбарлаж байна. Та нар хичээх хэрэгтэй, сайн хийх хэрэгтэй яагаад гэвэл бүх зүйлийг сайжруулахыг хүсч байгаа, та нар үүний төлөө үүрэг хүлээсэн, та нар амь бодийг аврах үүрэг, хариуцлагатай ирсэн. Түүхийн туршид хүмүүс амь бодийг аварна гэж андгайлдаг. Гэхдээ амь бодь аврахын жинхэнэ утгыг хэн мэдэх юм? Та нар амь бодийг жинхэнэ аварч байна, ийм аугаа үйл хэргийг зөвхөн та нар хийх хувьтай. Энэ боломжоо алдаж хэрхэвч болохгүй!

Би ингээд зогсоё гэж бодож байна. Дараа нь хэрэв та нарт асуух чухал зүйлс байвал асууж болно, би энэ үлдсэн цагт та нарт хариулъя. Та нарын ажлын явцад, өдөр тутмын амьдралд болон бясалгалд гардаг хувийн тухайн асуудлууд бол та нарын өөрсдийн бясалгалдаа дээшлэхэд тустай нөхцөл, хүчин зүйлс, тэдгээр зүйлийг та нар өөрсдөө ухамсарлан ойлгож сорилтыг давах ёстой зүйлс. Би та та нарыг өөрсдөө ухамсарлан ойлгож аугаа буян олох хэрэгтэй гэж бодож байна. Хэрэв би бүх асуултанд хариулчихбал чинийх биш болно.

Асуулт: Ариуслын бодол гаргахдаа барих гарын барил тарни болгонд нэг янзаар байх ёстой юу?
Багш: Үгүй, гарын ямар барилыг хоёр тарний алинтай хийхээ өөрсдөө шийдэж болно.

Асуулт: Фа цэвэрлэгээний үед зарим хүн Номын дагуу бүх зүйлийг хийхийн оронд Тэнгэрийн мэлмий нээгдсэн сурагчийн хэлэхийг дагаад байх юм.

Багш: Бүх тохиолдолд, та нар хамтдаа хийж байна уу эсвэл хувиараа Фа таниулж байна уу, бүгд Дафа-г удирдамжаа болгох ёстой, бүгдийг Фа дагуу таниулах ёстой, Тэнгэрийн мэлмий нээгдсэн хэн нэгний үгээр явж хэрхэвч болохгүй. Хэдийгээр ихэнх сурагчдын харж байгаа үнэн боловч бүхэл дүр зургийн зөвхөн нэг хэсэг, мөн энэ нь тэдний түвшинд хязгаарлагдсан бөгөөд заримдаа тэдний зууралдсан сэтгэлээс болж хуурамч үзэгдэл бас гардаг. Та бүхэнд хэлэхэд, энэ сансар ертөнцөд ямарч дээд Бурхан байсан түүний хувьд сансар ертөнц бол үл тайлагдах нууц юм. Тэр бас Фа цэвэрлэгээний үед аврал хэрэгтэй амь бодийн адил. Түүний харж чадах, ойлгох зүйл нь зөвхөн тэр байгаа түвшинд юм, бүхэл сансар ертөнцийн жинхэнэ байдал биш, тэгэх тусмаа Фа цэвэрлэгээний үед Дафа-гийн сурагчдын хийх ёстой жинхэнэ төгсгөлийн байдал ч биш. Тэдгээр бурхдыг юу ч хийж байсан, юу ч хэлсэн түүнд битгий итгэ, зүгээр л Аугаа Ном, Багшийн шаардлагын дагуу хийх ёстой зүйлээ л хий. Та нар бүхнийг зөв ариунаар хийх ёстой, энэ бол туйлын хариуцлагатай, туйлын гайхамшигтай! Хэн нэгний харснаар удирдуулж болохгүй.

Бусад Дафа сурагчдын хамт ямар нэгэн зүйлийг хийхэд маргаан гарах нь дамжиггүй, Та нар санал зөрөлдөх байдал гарах нь зайлшгүй. Яагаад вэ? Чиний зууралдсан сэтгэлийг ямар нэгэн байдлаар илрүүлэх хэрэгтэй, тэгээд чи түүнийгээ арилгана. Харин маргалдаанд үргэлж зөрөөд байвал асуудалтай, яагаад гэвэл чи дотогшоо харахгүй байна, бурууг өөрөөсөө хайхгүй байна. Та бүхэн Дафа-д хариуцлагатай хандах хүсэлтэй, энэ санаа чинь зөв. Гэхдээ заримдаа өөрийгөө анзаардаггүй, энгийн хүний зарим зууралдсан сэтгэл байх бүрэн боломжтой. Энэ асуудалд анхаарах хэрэгтэй.

Өнөөдөр Фа цэвэрлэгээний энэ шатанд ирэхэд Дафа сурагчдын хийж байгаа бүх зүйлсийг Багш баталгаажуулж байна. Би 1999 оны 7 сарын 20- оос өмнөх үеийн бүх Дафа сурагчдыг дээш дэвшүүлсэн, та нарын хамгийн дээд зэрэгт хүргэсэн. Би урьд, та нарын өөрчлөлт хамгийн анхдагч

бичил түвшингөөс эхэлнэ гэж хэлсэн. Зарим сурагчийн бясалгал их хурдан явагдаж байгааг мэддэг. Та нар урд бүгд тэгэж мэддэг байсан. Та нарын бүрэн өсөх, бясалгалын эцсийн дээд түвшинд хүрэх явц бол сүүлд Фа баталгаажуулах зорилготой юм. Хувийн бясалгалын үед Фа сайн сурсан бол хэлмэгдлийн үед Фа таниулах, хүмүүсийг аврах ажлыг сайн хийнэ, та нарын гадаргуй давхарга Фа цэвэрлэгээний үед дээд түвшинд тасралтгүй ижилсэнэ, хүний гадаргуйн үлдсэн хэсэг улам бүр багасна. Гэхдээ сайн зүйл хийхгүй байгаа, эсрэг талд орсон, эсвэл урагш алхахгүй байгаа сурагчдын бурханлаг талын бие давхарга давхаргаар уусан алга болж байгааг бид харсан. Мэдээж энэ үйл хэрэг арай дуусаагүй байгаа, Фа цэвэрлэгээ дуусаагүй байгаа учраас та нарт дахин сайн хийж амжих боломж бас байсаар байна. Хэлмэгдэл дуусахад нэг өдөр үлдсэн ч гэсэн тэр өдөрт бас найдвар байна. Үүнийг сайн ашигла, хурдан буцаж ор, дахиж энэ боломжоо бүү алд. Урьдын алдаан дээрээ битгий эргэлдээд бай, алдаа хийсэн бол одооноос эхлээд сайн хий. Өнгөрснийгээ битгий бодоод бай, одооноос яаж амь бодийн төлөө хүлээсэн өөрийнхээ үүргийг яаж сайн хийхээ л бод.

Би өөр нэг зүйлийг дурьдахыг хүсч байна. Манай зарим сурагчид хийж байгаа зүйл дээр нь санал зөрөлдөөн гарахад манай гэрийнхэн лүү утасдаж саналыг нь асуух дуртай байдаг. Би та нарт хэлье, миний гэр бүлийнхэн бас бясалгагчид, тэд бас олон зүйлийг тодорхой хэлж чадахгүй, алдаа ч гаргаж болно, буруу хэлж болно, тэдний хэлсэн нь Фа биш. Хойшид битгий иймэрхүү зүйл хийж бай. Өөрийнхөө аугаа буяны суурийг тавих, бясалгалдаа ахих боломжоо бүү түлх. Фа цэвэрлэгээний үед хүн болгон өөрийнхөө замаар явна, энэ бол Дафа-гийн сурагч болгоны бүтээсэн түүх. Ингээд би зогсоё, өөр асуулт байвал асууж болно.

Асуулт: Багш тэнгэрт ямар нэгэн зүйл хийхдээ яагаад бяцхан сурагчдыг туслалцуулдаг вэ?

Багш: Яагаад гэвэл тэдэнд томчуул шиг амьдралын явцад суусан үзэл бодол байхгүй, тэдний зан байдал илүү цэвэр, мөн тэднээс гарах энергид энгийн хүний бодол нөлөөлдөггүй. Нөгөө талаар чадвар нь энгийн хүнийх шиг наснаас хамаардаггүй.

Асуулт: Материаллаг амьдрал, мөнгөнд автсан Хонг Конгийн хүмүүст Дафа олж авахад яаж туслах вэ?

Багш: Та нар Дафа-гийн сурагчид, харгис үзэл суртлын худал ухуулганд хордсон хүмүүсийг аварч байна. Дафа-гийн эсрэг л биш хүн бол Фа хүний ертөнцийг цэвэрлэх үед устгагдах аюулаас гарч болно. Фа-гийн эсрэг зүйл хийгээгүй ч гэсэн муу хүмүүст, эсвэл сайн биш хүмүүст бид одоогоор юу ч хийхгүй. Учир нь, дараагийн үед бясалгал хийх хүмүүс байх болно, дараачийн үеийн хүмүүс Фа хүний ертөнцийг цэвэрлэх үед өөрсдийнхээ байрыг эзлэх хэрэгтэй болно. Одоо үед бид гол анхаарлаа харгис үзэл суртлын худал ухуулганд хордсон хүмүүсийг аврахад чиглүүлнэ. Бид хүмүүсийг аварч байхад тэдгээр туйлын харгис хүмүүс, амь бодиуд устгагдана, яагаад гэвэл тэд Фа-д хор учруулсан. Тэдний адил бас маш олон хүмүүс байгаа, гэхдээ тэд Фа-д хараахан хор учруулаагүй, энэ хэрэгт арай оролцоогүй хүмүүст юу ч битгий хий. Яагаад? Фа цэвэрлэгээний дараагийн үед бол Фа-д хор хүргээгүй хүмүүст боломж олгоно. Үүний зэрэгцээ дараагийн үеийн хүмүүс өөрсдийгөө бас бясалгах болно. Эдгээр зүйлс бол дараагийн үед хамаарна.

Дафа сурагчдын өнөөдрийн хийж байгаа зүйлс бол Дафа-д хүлээсэн үүрэг. Энгийн хүний нийгмийн зүйлсд битгий хүр. Үнэнийг таниулахдаа битгий дээд түвшний зүйл ярь, хүмүүс Фа-г ямар дээд түвшний, гүн гүнзгий болохыг ойлгох нь чухал биш. Харин үнэхээр сайн хүмүүст бол үүний талаар хэлж болно. Дундаж хүмүүст үнэнийг тайлбарлахдаа биднийг хавчин хэлмэгдүүлж

байна, бид зөвхөн дасгал хийдэг, сайн хүн байхыг л хичээдэг гэж ярихад тэд ойлгоно. Тэд үнэнийг мэдсэний дараа бүх зүйл худал суртал ухуулга байсныг ойлгоно, тэд улмаар үүнийг ямар хэрцгий, жигшүүртэй болохыг харна. Хүмүүс мэдсэний дараа дургүйцэх болно: "Төр яахлаараа ингэж бүлэг танхай этгээд шиг авирладаг байна аа? Та нарыг маш хэрцгий хэлмэгдүүлж байна, та нарыг зөвхөн сайн хүн байх гэсний төлөө хэлмэгдүүлж байна." Хүмүүстэй ярихдаа хамгийн энгийн үгээр ярь. Тэгвэл хүлээж авч ойлгоод зогсохгүй бас тэдэнд буруу дүгнэлт төрөхгүй. Та нар ийм удаан хугацаанд бясалгаж байна, Фа-г нилээд гүн ойлгож байна. Хэрэв Фа-г дээд түвшинд ойлгосноороо яривал энгийн хүмүүст ойлгоход хэцүү, буруугаар ойлгож магадгүй. Та нар удаан хугацаанд бясалгаж байж өнөөдөр дээд түвшинд ойлгодог болсон. Та нар хүмүүст шууд дээд түвшинд ойлгуулахыг хүсч байна, харин тэд хүлээн авч чадахгүй, тиймээс хэт дээд түвшинд битгий ярь. Шашин шүтдэг хүмүүст хүртэл битгий дээд түвшинд ярь. Өөрсдийнхөө хэлмэгдэж зовж байгаа талаар л ярь. Хэрэв тэд өөр шүтлэг бишрэлийн талаар сонсохыг хүсэхгүй бол битгий ярь, бид зүгээр л дасгал хийдэг гэж хэл. Өнөөгийн хүмүүсийг аврахад хэцүү. Та нар тэдний зууралдсан үзэл бодлын дагуу тайлбарлахаас өөр аргагүй. Хүн аврахын төлөө тэдэнд хүндрэл битгий учруул.

Асуулт: Би дөнгөж хэдэн сарын өмнө л Фа олж авсан сурагч. Би тэдгээр 1999 оны 7 сарын 22 оос өмнө Фа олсон сурагчдаас ямар ялгаатай вэ?

Багш: Хуучин хүчин бас зарим сурагчдыг хэлмэгдлийн үед Дафа-д орохоор зохицуулсан. Тэд бодохдоо хэлмэгдэл ширүүн байхад орж ирсэн хүний аугаа буян цойлон өснө гэж үзсэн. Бас дараагийн үед бясалгалын үр дүнд хүрэх бүлэг хүмүүс байгаа, тэд энд багтаагүй, одоо хэн нь ямар байдалтай байгааг тодорхой хэлэхэд хэцүү. Ямарч байсан Дафа олж авсан бол хамгаас аз завшаантай хэрэг, тиймээс та бүхэн энэ цаг үеийг сайн ашиглаж өөрийгээ жинхэнэ бясалгах, үнэхээр Фа олж бясалгалаар дээш ахих хэрэгтэй. Хүн болгон Фа олж чадахгүй, хүн болгон орж чадахгүй, яагаад гэвэл энэ бол Сансар ертөнцийн Аугаа Фа. Урьд намайг Дафа зааж байхад хуучин хүчин эхний ээлжинд Фа олох 100 сая хүнээр яагаад хязгаарласан бэ? Энэ 100 сая хүн ч гэсэн миний зүтгэсний хүчинд болсон юм. Тэр үед энэ тоог тэд яг 70 сая-аар хязгаарласан байсан, би 200 сая хүн байхыг хүссэн. Эхний ээлжинд 200 сая хүн Фа олж авбал энэ "сорилт" хэмээх харгис хэлмэгдэл болж чадахгүй гэдгийг тэд мэдэж байсан, тиймээс мухар 100 саяар хөдөлшгүй хязгаарласан. Тэдний дотор дөнгөж Фа олж авсан хүний тоо их хэмжээг эзэлж байсан, тэд үүнийг хүлээлгүй ад чөтгөрийн сорилтыг эхлүүлсэн. Тэдгээр хүмүүсийн хувьд энэ бол шударга бус. Саяхан Фа олж авсан хүмүүсийг аль хэсэгт багтахыг би хэлээгүй, та нар энэ талаар бодоод хэрэггүй, хийх ёстой зүйлээ л хийж бай.

Асуулт: Багшийн мэндийг эрье. Би нэг зүйл асуумаар байна, та нэг шинэ товхимолдоо "Гурамсан сав газрын шинэчлэл"-ийн тухай ярьсан. Сурагч бид сайн ойлгосонгүй, Багшаа та тайлбарлаж өгнө үү.

Багш: Үнэндээ чиний насны хүмүүс бол мэдэх ёстой. Тэдгээр урьд хувиараа ном заалгасан эсвэл 1950 оноос өмнө сургуульд сурсан хүмүүс бүгд сургуульд *Гурван ухагдахуун* заалгасан. Энэ *Гурван ухагдахуун* болон Хятадын соёлд үргэлж гурамсан сав газрын ойлголт байсан. Мөн Даогийн номлолд бас их дурьдсан байдаг. "Гурван сав газар" гэдэг нь үнэндээ Тэнгэр, Газар ба Хүн гурвыг хэлдэг. "Гурван сав газрын шинэчлэл" гэдэг нь Шинэ Тэнгэр, Шинэ Газар ба Шинэ Хүн гэсэн утгатай юм.

Асуулт: Багшийн мэндийг эрье. Би нэг асуулт асуух гэсэн юм. Кунцийн номлол Хятадын гүрэн болгоныг дамжиж ирсэн. Кунцийн номлол Хятадад Дафа дэлгэрэхэд ямар холбоотой вэ?

Багш: Кунцийн шашны талаар би саяхан ярьсан, энэ нь хүмүүсийн үзэл бодолд л зөвхөн суурь болсон. Хүмүүст алтан дундаж зарчмыг ойлгуулсан, мөн хүмүүсийн итгэж дагавал зохих тодорхой зүйлүүдийг: хүнлэг зан чанар, итгэл даах, ёс суртахуун, суралцах ухаан, үнэнч байдал, гэх мэтийн ойлголтыг өгсөн. Хүн төрөлхтөний үе болгоны соёл нь Фа олж авахад хүний үзэл бодол ямар байх ёстой суурийг тавьж өгсөн, Фа олж аваад дараа нь үүнийг ухамсарлах, ойлгоход дөхөм болгосон.

Асуулт: Бид одоо Дафа-гийн ажил маш их хийж байна, цаг зав тун бага байгаа. Өдөр болгон хоёр цаг дасгал хийх цаг гаргаж чадахгүй байна. Дасгалаа бага хийвэл болох уу?

Багш: Дафа-гийн шавь нараа, Багш нь та нарыг их зүтгэлтэй ажиллаж байгаа гэж хэлсэн, та нар үнэхээр шаргуу ажиллаж байна. Би та нарт өөр ямар нэгэн зүйлийг нэмж хий гэж хэлж зүрхлэхгүй болсон. Би олон хүн маш их санаачлагыг гартаа аван ажиллаж байгааг мэднэ, өдөр бүр бага унтах болдог, бас ажилдаа явах хэрэгтэй, энэ бол үнэхээр хэцүү. Гэхдээ ямарч хэцүү завгүй байсан Фа унших, дасгал хийх цаг гаргах хэрэгтэй, бясалгагч хүн дасгал хийхгүй байж болохгүй гэж бодож байна. Дасгал хийх нь чиний дээшлэхэд туслах чанартай ч гэсэн, энэ бас Фа-гийн нэг хэсэг, чиний биен дэх бүх өөрчлөлттэй уялдаа холбоотой. Мэдээж, хэрэв их олон зүйл хийх шаардлагатай маш завгүй бол дасгалаа бага хий, эсвэл хэдэн өдрөөр дасгалаа хийж чадаагүй бол яахав, дараа нь үргэлжлүүлээд хийж болно. Бүр их завгүй, дасгал хийх цаг үнэхээр бага бол Багшид нь үүнийг чамд шийдэж өгөх арга бас бий. Гэхдээ чиний бага зэрэг завгүй байгаа, бага зэрэг бэрхшээл үзэж байгаа бол би үүнийг Дафа сурагчийн аугаа буяны хэрэг гэж үзэж байна. Ирээдүйд чи эргэж харахад чамд гайхамшигтай байх болно!

Асуулт: Сансар ертөнцийн хамгийн дээд амь яаж бүтээгдсэн бэ?

Багш: Ирээдүйд би та нарт хамгийн дээд Фа ярина. Сансар ертөнц яаж бүтээгдсэн, энэ асуултаар ярина. Одоо энэ талаар ярихад арай эрт байна.

Асуулт: Би Фа уншиж байхад тэнгэрийн хүмүүс таван зуун жилд дахин төрдөг, дэлхийн хүмүүс зуун жилд дахин төрөл олдог гэж байсан. Энэ ямар учиртай вэ?

Багш: Гурамсан ертөнц бол сансар ертөнцийн хамгийн доод давхарга. Гурамсан ертөнц дотроо гурван том түвшинд хуваагддаг, тиймээс Гурамсан ертөнц гэж нэрлэгддэг. Түвшин болгон дотроо их тэнгэрийн гурван түвшинтэй буюу нийтдээ тэнгэрийн есөн түвшинтэй. Энэ тэнгэрийн есөн түвшин дотроо олон жижиг тэнгэрт хуваагддаг, тиймээс зарим хүн гучин гурван тэнгэрийн түвшин гэж хэлдэг, үнэндээ түүнээс ч олон. Энэ хүрээнд байгаа бүх амь бодь дахин төрөл олох замаар явдаг, харин Гурамсан ертөнцийн гаднах амь бодиуд тэгдэггүй. Гурамсан ертөнц доторхи амь бодь болгоны амьдрах нас харьцангуй богино: Дэлхийн хүмүүс зөвхөн хэдэн арван жил насалдаг, нэг түвшин дээгүүр амь бодь зуугаас хоёр зуун жил амьдардаг, дахиад нэг түвшин дээгүүр амь бодь хоёроос гурван зуу насалдаг, мөн түүнээс бас нэг түвшин дээгүүр амь бодь гурван зуугаас дөрвөн зуун жил насалдаг, тэгээд хамгийн дээд түвшний амь бодь ойролцоогоор мянган жил насалдаг. Гэхдээ хэдэн жил байсан ч яваандаа доош унаж дахин төрөл олох ёстой. Гурамсан ертөнцөөс гарсан амь бодь дахин төрөл олох замаар явахаа болино.

Асуулт: Дафа номын олон хувилбар гарсан, зарим үгнүүд нь өөрчлөгдсөн, алинаар нь явсан нь дээр вэ?

Багш: Бид буруу үг олбол залруулга хийх шаардлагатай. Багш энд байхад Фа замбараагүй болж болохгүй. Хятад номын хувьд бол Тайванд хамгийн сүүлд хэвлэгдсэнээр яв.

Асуулт: Би одоогийн сургуулийн систем Жэнь, Шань, Рэн-ээс улам хазайж байна гэж бодож байна. Хүүхдүүдийг робот мэт болгох гэж байгаа юм шиг хичээл зааж байна, яаж өөрийгээ зөв авч явах зарчмын талаар заахгүй задгай тавьж байна, буянг анхаарч үзэхгүй, нинжин (Шань) эсвэл тэвчээр (Рэн) заахгүй байна. Тиймээс би хүүхдээ сургуульд явуулахыг хүсэхгүй байна. Би хүүхдээ гэртээ байлгаж өөрөө заахыг хүсч байна. Би хэтэрхий туйлиширч байна уу? Ирээдүйд Дафа сургуультай болохыг хүсч байна.

Багш: Хүн төрөлхтөн ийм болсон учраас би одоо Фа заахдаа бас өнөөгийн шинжлэх ухааны дагуу ярьдаг. Хэдийгээр одоогийн сургуулиудад боловсрол олгохдоо хүүхдүүдэд сайн байхыг заахгүй дураар нь тавьдаг ч гэсэн тэр авсан мэдлэг нь хожим Фа ойлгоход тустай. Дафа сурагчдын байгуулсан сургууль байвал мэдээж сайн, гэхдээ тэр болтол бид хүүхдэд зарим мэдлэг өгч байсан нь дээр гэж бодож байна. Тэднийг гэртээ ирэхэд нь Жуан Фалунь уншиж өгч яаж өөрийгээ зөв авч явахыг зааж болно. Одоохондоо ингэж хийж байж болно. Шилжилтийн үе бол богино.

Асуулт: Сүүлчийн товхимолуудад яагаад олон ханз үсэг засагдсан бэ?

Багш: Сүүлд гарсан зургаан товхимолын талаар би утсаар хэлж бичүүлсэн. Минхуй вэб сайтанд буулгаж бичихдээ алдаа гаргасан. Минхуй-д товхимол гаргахыг зөвшөөрснийхээ дараа би гол төлөв дахин шалгадаггүй, зөвхөн хэн нэгэн ямар нэг ойлгогдохгүй зүйл олоод асуувал би хардаг. Надад тэр болгон шалгаж үзэж байх зав гардаггүй.

Асуулт: Би Солонгосоос ирсэн. Миний ойлгосноор Дафа-д хүн болгон адилхан. Гэхдээ олон шинэ сурагчдын зан заншил ялгаатай байдаг, энэ зүйлийн талаар тайлбарлаж өгнө үү.

Багш: Жуан Фалунь олон хэл дээр орчуулагдахад Фа-г ерөнхийд нь ойлгоход чамд нөлөөлөхгүй. Бясалгалын явцад, тухайлбал Фа-гийн гүн утга агуулга үгэн дээр ил гардаггүй. Чи номоо дахин дахин уншаад байвал Фа зарчмын шинэ, шинэ ойлголттой болоод л байна, улмаар бүр Фа олон зарчмыг харах болно. Энэ бол Фа чиний оюун ухааныг нээж өгч байгаа юм. Тэгэхээр чиний дээшлэхэд энэ байдал саад болохгүй. Хятадын их олон настай бичиг үсэггүй хүмүүс Фа үзэж байгаад уншиж сурсан, тэдний дээшлэхэд бас нөлөөлөөгүй.

Асуулт: Зарим шинэ сурагчид зан заншлын саад бэрхшээлтэй байдаг, үүнээс болоод Фа ойлгож чаддаггүй.

Багш: Шинэ сурагч аажмаар ойлгодог, тэдэнд хэт дээд түвшний зүйл битгий ярь. Зөвхөн өнгөцхөн зүйлийн талаар ярь, жишээ нь яаж зан чанараа дээшлүүлэх, яаж сайн эрүүл байх гэх мэт. Тэд яваандаа номоо уншсаар өөрийн ойлголттой болно.

Асуулт: Барууны олон хүмүүс биднээс дасгал сурахаар ирдэг, янз бүрийн насныхан байдаг. Бид Фа лекцийн адил Багийн хэлсэн дээр англи орчуулгыг нэмээд дасгалын хөгжмийн дууны бичлэг хийж болох уу?

Багш: Тэгж хийж болно, гэхдээ уншлагыг битгий орчуул. Уншлага бол энгийн хүмүүсийн хэлдгээр тарни юм. Ханз үсэг болгоны дуудлага сансар ертөнцийн тодорхой биесд хамааралтай байдаг. Үүнийг орчуулангуут зөв дуудлага, дотоод мөн чанар нь алдагддаг.

Асуулт: Би хэдэн зүйлийн талаар асуумаар байна. Олон Дафа сурагчдын хувьд гараад Фа дэлгэрүүлэхэд сайхан мэдрэмж төрдөг, мөн хүмүүстэй ойлголцоход нилээд амар байдаг гэж боддог. Харин тэдний гэрт нилээд бэрхшээл гардаг. Жишээ нь: зарим хүний эхнэр эсвэл нөхөр нь ойлгодоггүй. Манай эцэг эхийг аваад үзье, тэд Хятадад тодорхой нийгмийн байр суурьтай, тиймээс их дарамтанд байдаг. Гэхдээ би олон Дафа сурагчдын Хятадад байгаа төрөл төрөгсөд

Фалунь Гон-ыг сайн гэдгийг мэддэг гэж боддог, гэхдээ тэд биднийг гадаадад аюулд орох вий гэж айдаг. Би Дафа сурагчдын гэр бүлийнхэн зарим талаар бэрхшээл туулдаг гэж боддог. Фа цэвэрлэгээ хүмүүний орчлонд орж ирэхэд тэдэнд юу болох бол гэдгийг мэдмээр байна?

Багш: Энэ зууралдсан сэтгэлээсээ салах хэрэгтэй. Энэ үед Фа бүх амь бодийн оролцоог дүгнэж байна. Хэн нэгэн Фа-д муу зүйл хийгээгүй бол асуудалгүй. Харин Дафа-гийн талаар муу буруу бодолтой байвал бүх амийг аврах үүднээс та нар гэрийнхэндээ эхлээд тайлбарлаж өгөх хэрэгтэй, ойлгуулах гэж чармайх хэрэгтэй, тэгээд тэднийг муу бодлоос нь салгах хэрэгтэй.

Асуулт: Энэ Фа конференцийн дараа урлагийн тоглолт болно, энгийн хүмүүс оролцоно. Бид энгийн хүмүүсийн гайгүй сайн дуунаас дуулж болох уу?

Багш: Энгийн хүмүүс ирж бидний тоглолтыг үзэж болно, бид бүх амийг аварч байгаа. Тэд ирж манай Фа конференцийг сонсохыг ч зөвшөөрнө. Фа конференцийн үед сурагчдын ярьж байгаа зүйлс тэдэнд тустай. Энэ бол асуудалгүй. Энгийн хүмүүсийн дууг манай Дафа ариун танхимд дуулж болох уу гэж үү? Болохгүй. (Алга ташив) Яагаад болохгүй вэ? Хэрэв та нар энгийн хүмүүсийн тоглолтонд оролцвол, энэ нь Дафа-гийн сурагчид энгийн хүмүүсийн тоглолтонд оролцвол дууны сэдэв нь зөв бөгөөд улс төрийн бус бол асуудалгүй. Харин бүхэлдээ Дафа-гийн концерт бол бид үүнийг улам цэвэр ариун байлгах хэрэгтэй гэж бодож байна. Манай Дафа-гийн сурагчид зохион байгуулаагүй бол асуудалгүй. Та нар тодорхой ялгаж харах хэрэгтэй. Хэрэв зөв сайн дуу бол болох уу гэж асуусан. Одоо дууны зохиолч Дафа-г хэлмэгдүүлэхэд оролцсон эсэхийг та нар мэдэхэд хэцүү. Тэр хүн Хятадад Дафа-г хэлмэгдүүлсэн дуу бичээгүй гэдгийг яаж мэдэх юм? Та нар одоо үүнийг шүүж чадахгүй. Хэрэв хөгжмийн зохиолч Дафа-гийн сурагч, мөн дуу нь улс төрийн бус чиглэлийн бол яахав. Гэхдээ одоо үүнийг хэлэхэд хэцүү.

Асуулт: Эх газрын Хятадад байгаа сурагчид гараад Фа тараах юм бол баривчлагдах нь тодорхой. Гэхдээ Фа дэлгэрүүлэхгүй бол Фа цэвэрлэгээний үед тэдний түвшинд нөлөөлнө гэхээс айдаг. Хятадын эх газрын сурагчид үүнд яаж хандвал зохистой вэ?

Багш: Энэ бодол нь хоёулаа буруу. Хэрэв гарч Дафа дэлгэрүүлэхгүй, айгаад байвал түүний түвшинд нөлөөлнө, тэр үүнийг хийхээс айгаад байвал дээшлэхгүй, ингээд айгаад байвал түүний гэгээрлийн хутаг олоход саад болно. Тэр жинхэнэ Дафа-гийн сурагч байхын оронд үүнээс ч түүнээс ч айсан. Дафа-гийн сурагчид Фа-г баталгаажуулах ёстой, амь бодийг аврах ёстой. Энэ нь яг энгийн хүний зууралдсан сэтгэл учраас асуудал амархан гарна, тийм ч учраас бас олон асуулт гарч байна.

Би Хятадын дотоод байдлыг бүрэн мэднэ, би маш сайн мэдэж байгаа. Дафа-гийн сурагч Фа баталгаажуулахгүй байж болохгүй гэж би хэлнэ. Би бүхнийг тодорхой хэлж өгч чадахгүй. Олон зүйлийг хуучин хүчин зохион байгуулсан. Үүнээс гадна, тэд үүнийг маш нарийн төлөвлөсөн, мөн маш эдрээтэй бөгөөд төвөгтэй байдлаар илэрдэг. Эх газрын Хятадын байдал замбараагүй мэт харагдах боловч үнэндээ маш нарийн зохицуулагдсан.

Тэд хоёр нөхцөлд Дафа-гийн сурагчид хүрч чадахгүй: Нэгд хэрэв тэр очир алмааз шиг бат бөх хөдөлшгүй байвал тэд хүрч зүрхлэхгүй, яагаад гэвэл тэр сурагч ариун замаар явж өөрийгээ зөв барьж байхад хуучин хүчин эсвэл хуучин зарчим байх нь хамаагүй түүнийг хэлмэгдүүлж зүрхэлбэл тэднийг би өршөөхгүйг мэднэ. Миний талд бас тоолшгүй олон ариун Бурхад бий! Надад бас тоолшгүй олон Номын биес байгаа, тэд бүгд Фа цэвэрлэгээ хийж чадна. Миний ганц санаа зовж байгаа зүйл бол Дафа-гийн сурагч өөртөө бат тууштай хандаж чадахгүй бол, зарим зууралдсан сэтгэл гарахад, аливаа айх сэтгэл төрөхөд хуучин хүчин энэ сул талыг ашиглан

хэлмэгдүүлдэг. Мөн хэлмэгдэлд байхдаа сурагчийн бодол зөв байхгүй бол хэлмэгдэл улам хүндэрнэ. Үргэлж ийм байдаг. Мөн ийм сурагчдын ихэнх нь түүхэнд надтай шууд хувь тавилангийн холбоо тогтоогоогүй хүмүүс байдаг. Фа дэлгэрч байгаа энэ үед үүд өргөн нээлттэй байгаа, хуучин хүчин тэдний орж ирэхийг зогсоож чадаагүй. Гэхдээ ийм сурагчдын ихэнх нь өөртөө зөв хандаж байгаа. Түүхэнд надтай хувь тавилангийн холбоо тогтоосон сурагчдыг тэд хүчтэй хэлмэгдүүлж зүрхлэхгүй, яагаад гэвэл урд түүхэнд тэдгээр сурагчид энэ мэтээр их зовж байсан. Хэрэв Дафа-гийн сурагч болгон ямар хэсэгт багтдаг нь хамаагүй бүгд сайн хийж чадсан бол энэ хэлмэгдэл аль эрт дуусах байсан. Сайн хийж чадахын хувьд ярихад амар, хийхэд хэцүү. Би бүгдэд ингэж хийх хэрэгтэй гэж хэлээд тэд хийж чаддаг болчихгүй. Энэ нь бясалгалаар бат суурьтай болж байж, Фа удаан хугацаанд уншиж байж тийм болдог. Үнэндээ бидний ихэнх нь өөрийгээ зөв барьж байгаа. Тэдгээр сайн байж чадаагүй сурагчид бол гуравдугаар бүлгийн сурагчид. Тэд сайн байж чадаагүй учраас хэлмэгдэл улам ширүүссэн, Дафа-гийн хэлмэгдэл маш ширүүн харгис байдалтай болсон. Үнэндээ аль бүлэгт багтсан нь хамаагүй Багш бүгдэнд адилхан ханддаг. Эх газрын Хятадаас өөр газар байгаа сурагчдад үхэл амьдралын бодлоос салах талаар ярихад тийм нөхцөл байдалд, тийм дарамтанд байгаа сурагчдад үхэл амьдралын бодлоос салах тухай ярихаас их ялгаатай. Би энэ талаар их зүйл хэлмээргүй байна. Хэрэв тийм нөхцөлд үхэл амьдралын бодлоос үнэхээр салж чадвал байдал өөрөөр эргэнэ. Жишээ нь, зарим Дафа сурагчид баригдаад хөдөлшгүй тайван байж чаддаг, тэдэнд айх сэтгэл байдаггүй. Хуучин хүчин тийм сурагчдыг хэлмэгдүүлж чадахгүй. Яагаад гэвэл тэд ийм сурагчийг үхтэл нь зодсон ч ямар ч хэлмэгдэл үйлчлэхгүй гэдгийг мэднэ, тиймээс тэдэнд хүрэхгүй. Хэр олон сурагчид тийм байж чадах вэ? Дафа-д тууштай байгаа амь бодь харгис хүчинг айлгана. Үүний эсрэгээр энгийн хүний их зууралдсан сэтгэлтэй, Фа гүн сайн сураагүй хүмүүс эдлэх ёсгүй зовлон өөртөө их авчирдаг. Тэдний зарим нь "буруугаа хүлээх бичиг" гэх мэтийн зүйлд гарын үсгээ зурсан. Би энэ хэлмэгдлийг хүлээн зөвшөөрдөггүй учраас энэ байдал дуусаагүй байхад тэдэнд би дахин боломж өгнө. Би ихэнх сурагчид хэлмэгдэлд орсныхоо дараа тэд Дафа болон бясалгал ямар чухал болохыг улам ойлгосон, үүнд улам нухацтай зөв хандах болсныг харсан. Тэд мөн энэ хэлмэгдлийг ямар ноцтой болохыг улам тод харсан, үүнээс хойш тэд юм хийхдээ урьдынх шиг энгийн хүний их зууралдсан сэтгэлээр хийхээ больсон. Тэд аажмаар энэ зууралдсан сэтгэлээсээ салсан учраас үйлдэл нь улам цэвэр ариун, улам сайн болсон. Тэд улам тууштай бөгөөд зөв бодлоготой болсон. Хэлмэгдлийг зөвхөн өнгөн дээр нь битгий хар. Фа цэвэрлэгээ хүмүүний орчлонд орж ирэхэд хүмүүсийн нүдний өмнө бүх үнэн илт болно. Эх газрын Хятадын сурагчид үнэхээр гайхамшигтай.

Асуулт: Би хоёр асуулт асуумаар байна. Эхний асуулт бол Хятадад амьдардаггүй зарим Дафа сурагчдын төрөл төрөгсөд, найз нөхөд нь хичээллэдэг байсан, харин хэлмэгдэл эхэлсний дараа аажмаар хийхээ больсон. Тэд одоо яах хэрэгтэй вэ гэж асууж байна. Хоёр дахь асуулт бол зарим их хичээнгүй сурагчдад хүртэл өвчний карма хүчтэй гарах юм. Тэд үүнийг өөрсдийн нүглээс болж байна уу эсвэл харгис хүчний нөлөөнөөс болж байна уу гэдгийг мэдэхийг хүсч байна. Тэд үүнд яаж хандвал зохистой вэ?

Багш: Эхний асуултын хувьд тэд юу хийхийг хүсч байна, тэдний хэрэг, энэ бол үнэхээр өөрсдөөс нь хамаарна. Хоёр дахь асуултын хувьд, ямар нэгэн асуудал гарахад шалтгааныг эхлээд өөрөөсөө хай, энэ бол Дафа сурагчдын энгийн хүнээс ялгарах чухал онцлог. Хэрэв бидний зүгээс асуудал байхгүй бол тэр нь харгис хүчний Дафа-гийн сурагчдад учруулж байгаа хэлмэгдүүлэл байж таарна. Фа цэвэрлэгээний энэ үед Дафа-гийн сурагчийн карма бол асуудал биш. Та нар харгис хүчний хэлмэгдүүллийг тодорхой ялган харах хэрэгтэй. Тэд үнэхээр муу зүйл хийж байна. Дафа

сурагчид өөрийн замаараа зөв явж харгис хүчинд өөрсдийгээ хэлмэгдүүлэх ямарч шалтаг гаргахгүй байх хэрэгтэй.

Асуулт: Шинэ сансар ертөнц ямар вэ? Жоохон төсөөлөл өгнө үү.

Багш: Хүн төрөлхтөнд өөрчлөлт бас гарна. Сансар ертөнцөөс хүн төрөлхтнийг хүртэл өөрчлөлт явагдана. Шинэ сансар ертөнцөд хуучин сансар ертөнцөд байсан олон талын дутагдалтай шинж чанарууд засагдсан. Шинэ сансар ертөнц бол илүү төгс төгөлдөр, үүнийг урьд Фа цэвэрлэгээ хийхгүйгээр шийдвэрлэх ямарч арга байгаагүй. Урьд сансар ертөнцийн муудах үе ирэх болгонд задран устаж шинээр бүтээгдэж байсан, дахин хөгжиж эхэлдэг байсан, дахин муу болоход дахиад л шинээр бүтээгдэнэ. Сансар ертөнц үүссэн цагаас хойш анх удаагаа Фа цэвэрлэгээ болж байна. Тиймээс би Фа цэвэрлэгээний энэ боломжийг ашиглан олон зүйлийг өөрчилсөн, гэхдээ би энэ талаар ярьж болохгүй. Харин хүн төрөлхтөн сансар ертөнцийн нэг хэсэг болохоор, мөн Дафа энд дэлгэрсний хувьд би нэг зүйлийг хэлж болно, энэ нь урьд өмнө хүн төрөл хэзээч энд оршиж байгаагүй, хэдэн ч удаа дэлхий сөнөж дахин бүтээгдэж байсан энд байсан үндсэн амь бодь бол үргэлж харь гаригийн төрлийнхөн байсан. Тэдний гаднах төрх удаа дараа бүрд их ялгаатай байсан, гэхдээ аль нь ч гадаад хэлбэр болон дотоод эрхтэн систем нь мөн бодол санаа нь хүнийхтэй адил байгаагүй. Өнөөгийн хүн төрөлхтөн бол Дафа-г дэлгэрүүлэхийн тулд бүтээгдсэн. Тиймээс Дафа-гийн эсрэг нүгэл хийсэн хүмүүс устана, үлдсэн хүмүүс аз жаргал ивээл хүртэнэ. Ирээдүйд дэлхийн оршин суугчид хүний дүр төрхтэй байх болно. Өөрөөр хэлбэл, дараагийн үе шатанд ирээдүйн хүн төрөлхтөний суурь жинхэнэ тавигдаж эхлэнэ. Энэ удаа амь бодийн хэлбэр төрх Дафа дэлгэрүүлэхийн тулд бүтээгдсэн. Ирээдүйд мөн адил Будда, Дао нар, болон Бурхад дэлхийд бууж ирж хүмүүсийг аварна, оюун ухаант амь бодиуд Фа сонсох боломжтой байх болно, дахин аврагдах болно. Гэхдээ Бурхан хүн аврах гэж ирээд цовдлуулах байдал дахин хэзээ ч гарахгүй.

Асуулт: Надад ийм нэгэн асуулт байна: Заримдаа үнэнийг тайлбарлахад түүхт хүмүүсийн талаар яригддаг, бид хувь тавилангийн нарийн холбоог мэдэхгүй, зарим асуудалд болгоомжтой хандсан нь дээр үү?

Багш: Фа цэвэрлэгээний үед та нар зөвхөн энгийн хүний үгээр, хүмүүсийн амархан ойлгох байдлаар Фа-г таниулах хэрэгтэй. Одоогийн хүмүүсийн сайн мууг, зөв бурууг ойлгодог байдлаар ярихад хангалттай. Түүхэнд байсан хэнийг ч дурьдсан асуудалгүй.

Асуулт: Таны саяхан эх газрын сурагчдын байдал нилээд сайн гэж ярьсантай холбогдуулан нэг жишээ хэлмээр байна. Миний нэг таньдаг хүний хэлснээр манай бараг бүх гэрийнхэн, найз нөхөд бүгд их тууштай. Тэдний зарим нь Тиананмэнь талбай дээр очоод ил тод зоригтой байдаг. Тэд өглөө яваад орой ирдэг, өглөө онгоцоор яваад орой онгоцоор ирдэг. Тэд "Фалун Дафа сайн!" гэж чанга хашгираад зогсохгүй бас лоозон дэлгэн барьдаг ч тэдэнд аюул тохиолддоггүй. Нэг наяд гарсан настай хүн байдаг, тэр өдөр болгон гарч Фа түгээдэг ч түүнд юу ч тохиолддоггүй. Тэд бүгд их зүтгэлтэй. Миний мэдэхээр зөвхөн нэг хүн баривчлагдсан, гэхдээ тэр өөрийгээ их сайнаар харуулдаг байсан. Би тэдэнтэй ярихад их сайхан байдаг. Тэд надад "Бид дажгүй, бүгд сайн байгаа" гэж хэлдэг. Үүнийг сонсоход надад сайхан байдаг.

Багш: Байдал одоо ийм л байгаа. Яагаад гэвэл одоо хуучин хүчний ашиглах харгис хүмүүс тийм олон байхаа больсон. Хоёрдугаарт, Дафа сурагчид ариуслын бодлоор цэвэрлэгээ хийхэд тэд зугтдаг. Та нар Хятадын элчин дээр очиж үнэнийг мэдүүлэхэд элчингийнхэн айсан янзтай байдаг. Энэ бол үнэндээ хүн айж байгаа юм биш, хүнийг удирдаж байгаа тэр муу амь бодь айж байгаа юм. Энэ хүний орон зайд илрэхдээ тэд айсан харагддаг, энэ бол харгис хүчин зүйлс айж байдаг.

Хэрэв харгис хүчин бүрмөсөн уствал тэр үед элчингийн хүмүүс хүртэл гарч ирээд биднээс Фалунь Гон суралцана, тэгвэл Хятадын улс төрийн толгойлогч тэр адгийн муу хүн үхтлээ айна. Тиймээс харгис хүчин элчингүүдэд ажилладаг хүмүүсийг хатуу барьж байхыг боддог, муу зүйлээ үргэлжлүүлэн хийхийг боддог. Хэдий тийм ч гэсэн тэд үргэлжлүүлж чадахаа больсон. Хятадад, харгис хүчний толгойлогч байдаг хотоос бусад газруудад муу хүчин бүх газрыг удирдаж чадахаа больсон. Харгис хүчин маш ихээр устгагдсан, тийм их үлдээгүй, ихэнх газруудад байдал гайгүй болж байгаа. Хэрэв та нар харгис хүчний толгойлогчийн ойролцоо ариуслын бодол гаргаж цэвэрлэгээ хийвэл харгис хүчин хурдан нөхөн сэргэгдэж, хамгаалагдаж чадахгүй, тэр амьтан эцсийн амьсгалаа хураана. Учир нь бол түүнээс хүний зүйлс юу ч үлдээгүй, түүний арьс бүхэлдээ харгис хүчнээр тэжээгдэж байдаг, ариуслын бодол гаргахад тэд устдаг. Хэрэв тэр нөхөн сэргэлт нь зогсвол тэр үхнэ. Өнгөрсөн удаа Малта-д түүний ойролцоо сурагчид ариуслын бодол гаргахад тэр бараг үхэх шахсан. Ийм л байдаг. Түүний дотор хүний юу ч байхгүй. Одоо тэр мэдрэмжээ алдсан, хэвийн хүний байдлаар сэтгэхээ больсон. Тэр бидний тулд амьд байна. Түүний хүн байх утга учир нь улам багассаар байна. Үнэндээ зарим газрын элчингийн ажилчид гарч ирээд манай сурагчидтай уулздаг болсон, зарим нь бидний материалаас сэмхэн авдаг болсон, бидэнд нууцаар "Сайн байна!" гэж хэлдэг болсон (Алга ташив). Урьд бол ингэж чаддаггүй байсан. Яагаад ийм болов? Хүмүүсийг удирдаж байсан харгис амь бодь устахад хүмүүс тайвнаар боддог болж ирсэн. Тэд одоо өөрсдөө "Фалунь Гон гэж чухам юу юм бол? Яагаад Фалунь Гон-ыг ингэж хэлмэгдүүлж байгаа юм бол?" гэж боддог болсон. Тэд энэ харгис хэлмэгдлийн илчлэгдсэн бүх худал явуулгыг хараад их түгшиж байна, өөрсдөө үнэнийг мэдэхийн төлөө хөөцөлдөж байна.

Асуулт: Надад хоёр асуулт байна. Бид FGM телевизийн нэвтрүүлэг дээр ажилладаг. Сүүлийн үед бид зарим үзэгчдээс манай мэдээллийн нэвтрүүлгийг хэтэрхий ширүүн сонсогддог гэсэн шүүмж өгсөн.

Багш: Би энэ нэвтрүүлгийн өнгө аяс нь нилээд сайн гэж бодож байна. (Алга ташив) Үүнд ангийн тэмцлийн зүйл байхгүй харьцангуй дундын. Хэрэв хэт зөөлөн сонсогдвол бас дэмий. Би Радио Телевизийн олон газруудад Лос Анжелосын сурагчдын хийж байгаа нэвтрүүлэг нилээд зүй зохистой гэж хэлсэн. Энэ нь хэт ширүүн ч биш хэт зөөлөн ч биш яг таарсан. Гахдээ багш магтсан болохоор үүнд битгий анхаар гэсэн үг биш, би та нарыг боломжийн хэрээр таарсан нийцсэн байх нь дээр гэж хэлж байна. Тэр нь дээр. Энгийн хүмүүс янз бүрийн зүйл хэлнэ, бүх хүний санаанд нийцүүлэхэд хэцүү, зарим хүн халуун ногоотой хоолонд дуртай, зарим хүн исгэлэн юманд дуртай зарим нь чихэрлэг юманд дуртай. Бид зүгээр аль нийцтэй байдлыг л тусгасан нь дээр, тэгж л хий. Мэдээж бага зэрэг энгийн чөлөөтэй байж болно. Чи кино камерийн өмнө гарахад жүжигчин, тэгэхээр гадаад үзэмжиндээ бас арай илүү анхаарах хэрэгтэй.

Асуулт: Надад өөр нэг асуулт байна. Дафа-гийн нэвтрүүлэг хийхийн хажуугаар бид бас энгийн хүмүүсийн хийдэг шиг ямарч Дафа-гийн зүйл ороогүй нэвтрүүлэг хийдэг. Бид энэ харьцааг яаж зөв барих вэ? Дафа нэвтрүүлгийн цаг хэр удаан байвал дээр вэ? Мөн энгийн нэвтрүүлэгт үлдсэн хэр хэмжээний цагийг зориулсан нь тохиромжтой вэ?

Багш: Та нар өөрсдийнхөөрөө шийд, тодорхой зүйлийг яаж хийх нь та нарын хэрэг. Хоорондоо зөвлөөд ямар байх нь тохиромжтой байна түүгээрээ л шийд. Үнэн хэрэгтээ Фа таниулж байгаа өнөө үед, Дафа сурагчдын үнэнийг ойлгуулж байгаа нь та нарын хэрэглэж байгаа янз бүрийн талын бүх арга зам бол бүгд сайн. Хятад руу илгээж байгаа ганц таниулах хуудас, мэдээлэл болон утсаар ганц ярьсан ч нэг факс явуулсан ч, мөн олон хэлбэрийн таниулах материал явуулж байгааг битгий дугуу үнэл, үр дүн нь нилээд илт байгаа, харгис хүчнийг айлгах, устгах нөлөө их байгаа, үнэхээр их. Харгис хүчний өгсөн худал хуурмаг сурталчилгаа хүмүүсийн тархинд муу ойлголт

үлдээсэн. Тэр харгис бодол санаа нь устаж замрахад хүмүүсийн толгой сэргэг болдог. Хүн үнэхээр аугаа том сансарын биетийг төлөөлж байгаа бол тэр хүн зөв эргэвэл тоо томшгүй олон амь бодь аврагдаж байна гэсэн үг, үзүүлэх нөлөө асар их! Энэ бүгдийг үнэхээр сайн хийж байна. Эдгээр зүйлсийг битгий дутуу үнэл. Яаж эдгээр зүйлсийг хийвэл тохиромжтой байна, яавал хүмүүс илүү хүлээж авах вэ гэдэг дээр өөрсдөө бодож үз, шийд. Хэрэв өргөн нэвтрүүлгийн хэлбэр энгийн хүний нийгэмд зориулсан бол энгийн хүн хүлээж авахаар байх хэрэгтэй. Үүнд хэлмэгдлийг илчлэх талын мэдээллээс өөр юу ч байхгүй бол харгис явуулгыг илчлэх, хүмүүсийг аврахад хамгийн сайн нөлөө үзүүлэхгүй, яагаад гэвэл үзэх сонсох хүмүүс нь бясалгадаг хүмүүс биш. Тиймээс бид энэ нэвтрүүлгийн хөтөлбөрийг илүү олон талын, хүмүүст илүү сонирхолтой байхаар хийвэл тэд үзэх болно. Үүний хажуугаар Дафа-гийн мэдээллийг оруулж өгөх хэрэгтэй. Ингэж хийвэл энгийн хүмүүст илүү нөлөөлнө. Энгийн хүний нийгэмд хийж байгаа нэвтрүүлэг болохоор энгийн хүмүүсийн үздэг агуулгатай зүйлс оруулахгүй бол болохгүй. Тэгвэл хэр хэмжээгээр үүнийг оруулахаа цэгнэж өөрсдөө шийд, тохиромжтой харьцаатай байх хэрэгтэй.

Асуулт: Багийн хотын Чанчуны сурагчдаас Багшид мэндчилж байна! Хэзээ та буцаж ирж бидэнтэй уулзах вэ?

Багш: Би цаг хугацаа их удахгүй байх гэж бодож байна. Хятадад нэг Гүрэний дараа өөр нэг Гүрэнээр ээлжлэн солигдож ирсэн. Тэр үед Гүрэн болгоны эзэн хаан "арван мянган жил орших болтугай" гэж хэлдэг байсан. Хэн тийм удаан амьдарч чадах юм. Гүрэн болгоноо үргэлж хүчирхэг, бат бэх байлгахыг хүсдэг байсан, гэхдээ эвдэршгүй байж чадаагүй. Бид Хятадын засаг төрийг эргүүлэхийг хүсээгүй, бидэнд тийм улс төрийн зорилго байхгүй. Бидэнд ямарч буруу байхгүй байхад хууль бусаар хэлмэгдүүлж байна, бид зөвхөн биднийг хэлмэгдүүлж байгаа тэдгээр харгис бүлэглэлийг илчлэхийг хүсч байна. Хятадын төрийн олон хүмүүс үнэндээ энэ хэлмэгдүүллийн эсрэг байдаг. Тэд зөвхөн хатуу шахалтын дор юу ч хэлж зүрхэлдэггүй. Гэхдээ хүмүүсийн юу хийж байгаагаас тэдний ирээдүй шалтгаална. Дафа бүх хүнийг цэгнэж байгаа. Би дахиад хэлье: Хүний нийгэм Дафа-гийн тулд үүссэн, түүхийн туршид Дафа-тай холбогдолгүй ямар ч зүйл хэзээ ч байгаагүй. Энэ бол харгис хүчний толгойлогч "Коммунист нам Фалунь Гон-ыг ялна" гэж хэлж байсан. Яагаад Хятадын Коммунист нам Фалунь Гон-ыг ялахыг хүсч байна вэ? Дэлхийн хүмүүс үүнийг хараад гайхаж байна, "Хятадын Коммунист нам Хятадын бүх арми, цагдаа, засаг захиргаа бүгдийг атгандаа авсан. Яагаад өөрийнх нь хараан дор байдаг зэвсэггүй энгийн номхон хүмүүсийг, зөвхөн сайн хүн байхыг хүсдэг хүмүүсийг ялах гэж? Ямар ухаангүй байна!" Дафа өргөн дэлгэрч хүмүүсийн сэтгэл санаа сайжирч эхэлсэн, мөн нийгмийн байдал тогтвортой болж ирсэн. Энэ нь хэнд тус хүргэж байна? Засгийн эрхэнд байгаа хүмүүст тустай биш гэж үү? Тэдэнд эрүүл ухаан гэж байна уу? Бид улс төрд хүчирхэг болох сонирхол байхгүй. Үнэндээ хэлмэгдэл эхлэхээс өмнө ХКН-ын Төв хорооны улс төрийн 7 гишүүдийн гэр бүлийнхэн Фалунь Гон-оор хичээллэж байсан, Улс төрийн бүх 7 гишүүд ном уншсан. Тэд бүгд Фалунь Гон гэж юу болохыг сайн мэднэ. Улс төрийн өрсөлдөөний үед гарсан атаархал нь хүмүүсийн нэг нэгэнлүүгээ дайрч давшлах хоорондын зөрчлийг өдөөсөн, түүнийг ухаанаа алдахад хүргэсэн, тэр эвлэрэхийг тэвчихгүй. Түүний бодлын хүрээ хэт богино, хүсэл шунал нь хязгааргүй, түүний эр зориг нь хариугүй өчүүхэн, атаархал хорсол нь туйлын их. Тэд улсыг ноёлхоос өөр зүйл мэдэхгүй, тэдний бодитоор хийж чадах зүйл нь дотоодын аж ахуйн салбарын удирдагчийн чадварт ч хүрэхгүй. Ухамсар, ухаангүй болоход ад чөтгөрөөс ялгаагүй болдог. Үүнээс гадна түүний Эзэн сүнс бах мэлхий. Түүн шиг хэн нэгнийг олоход хэцүү! Энэ хүмүүний орчлонгийн тоглолтонд хаанаас ийм жүжигчинг олох юм? Үүнийг олоход түүхийн их урт хугацаа шаардагдсан! *(Алга ташиг)* Хуучин хүчин үүнийг там руу хурдан унагахыг хүсэхгүй, яагаад гэвэл тэд ийм амьтныг дахиад хэзээ ч олж чадахгүй гэдгээ мэднэ.

